Амжилт гэдэг хэр их мөнгө олсонд бус хэдэн хүний амьдрал өөрчилсөнд оршино

Мишель Обама

МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2019.05.24, БААСАН ~ №098 (1150)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000₮

Ерөнхийлөгч Х.Баттулга УИХ-ыг тарахыг дахин шаардлаа

УИХ-ын гишүүд ард түмний төлөөлөл байх ёс зүйн чадамжаа үндсэндээ алдаад байна гэлээ. > 2

Залуусын хөгжлийн бодлого залуургүй болсон

Залуусын хөгжлийг дэмжих хуулийг хоёр жилийн өмнө баталсан ч мэддэг хүн тун ховор. > 5

Жолоочийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай

Даатгуулагчдын 95 хувь нь нэг ч удаа нөхөн төлбөр гаргуулаагүй байна. > 6

ZGM DAILY

FULL ENGLISH PAGE INSIDE > 7

ОНЦЛОХ

УЛС ТӨР

ТЕГ-ын дарга асан Б.Хурцыг хорьж байгаад шалгах шаардлагагүй гэж үзээд суллав.

Ерөнхийлөгч татварын хуульд тавьсан хоригоо тайлбарлаж, мэдэгдэл гаргалаа.

ЭДИЙН ЗАСАГ

Хонь, ямааны махны экспорт өнгөрсөн сард 2.5 сая ам.долларт хүрчээ.

Автомашин үйлдвэрлэгчид нийт 38 мянган ажлын байраа танахаар төлөвлөж байна.

НИЙГЭМ

Сүрьеэгийн халдварт арга хэмжээ аваагүй ЭМ-ийн сайдыг огцрохыг шаардаж, жагслаа.

УБ-т явуулах боломжтой цахилгаан соронзон галт тэргийг НИТХ-ын даргад танилцуулав.

ДЭЛХИЙ

Н.Моди сонгуульд ялах мэдээг дагаад Энэтхэгийн хувьцааны зах зээл дээшиллээ.

8 658000 029112 01150

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

МАНАЙ ЭКСПОРТ ХЯТАДЫН ГАНЦ ӨДРИЙН ХЭРЭГЦЭЭГ Ч ХАНГАХГҮЙ

Өмнөд хөршийн иргэд өдөрт дунджаар 208 мянган тонн мах зооглодог бол Монгол Улсын махны нийт экспорт 2018 онд 54.9 мянган тонноор хэмжигдэж байна. Монголын махны нийт экспорт Хятадын нэг өдрийн хэрэгцээг ч хангаж чадахгүй юм. ▶ 12

Ж.Гэрэлчулуун / ЗГМ©

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

Цөхөрч туйлдсан иргэдийн эцсийн сонголт гэмт хэрэг болов уу

Г.Баярсайхан
@bayarsaikhanZGM

НҮБ болон статистик мэдээллийн Numbeo байгууллага хамтран улс орнуудын гэмт хэргийн тоон үзүүлэлтийг жил бүр гаргадаг. 2018 оны үзүүлэлтийг Венесуэл улс 83.23 оноогоор тэргүүлж, Папуа Шинэ Гвиней (79.88), Гондурас (76.84), Өмнөд Африк (76.80), Афганистан (76.63) эхний тавд багтаж, муугаараа цоллуулжээ. Энэ жагсаалтыг сүүлийн жилүүдэд байнга тэргүүлж буй Венесуэлд 1999 оноос гэмт хэргийн гаралт огцом нэмэгдэх болжээ.

Сонирхолтой нь популист улстөрч Уго Чавес яг тэр жил Венесуэлийн Ерөнхийлөгч болсон байна. Санамсаргүй давхцал уу эсвэл хоорондоо нягт хамааралтай гинжин хэлхээ юу гэдэг сонин. Тухайн үеийн Венесуэл улсад 100 мянган хүн ам тутамд ногдох хүн амины хэргийн тоо 20 байсан бол үүнээс хойш жил бүр тасралтгүй өссөөр 2016 онд оргил үзүүлэлт болох 92-т хүрч эрс өссөн байх юм. Гэхдээ энэ нь мэдээж дэлхийд тэргүүлэх үзүүлэлт.

Хүүхэд хулгайлах тохиолдол тухайн үед жилд 40 орчим бүртгэгддэг байсан бол 2011 онд 1150-д хүрэх жишээний. Энэ мэтээр болж бүтэхгүй бүх муу үзүүлэлтээр Венесуэл дэлхийд цойлох болсоор хэдэн жилийг үдлээ. Энэ улсад сүүлийн хоёр жил гэмт хэргийн тоо бага зэрэг буурч буй таатай мэдээ бий.

▶ 3

Ц.Монгол: Монголынхоо баялгийг сорчилж, ухаж төнхөөд байгаа нөхдүүдийг өмгөөлөх дургүй

З.Үлэмж

Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн, Хуульчдын холбооны гишүүн, хуульч, өмгөөлөгч Ц.Монголтой ярилцлаа.

-Та сүүлийн үед тогтолцооны өөрчлөлтийн талаар илүү идэвхтэй байр сууриа илэрхийлж байх шиг. Энэ тухай яриагаа эхлэх үү?

-Тиймээ. Тогтолцооны гажуудлыг хэрхэн засаж өөрчлөх талаасаа гэвэл илүү зохимжтой болов уу. Үнэнийг хэлэхэд хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэл, шүүх эрх мэдлийн эрх зүйн зохицуулалт муу байгаа юм. Одоо манай улс нэг парламенттай, Ерөнхийлөгч, Үндсэн хуулийн Цэц, Засгийн газар, шүүх гээд төрийн эрх мэдэл нь тав хуваагдсан стандарт бус “гаж” тогтолцоотой явж ирлээ. Энэ нь дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн төрийн гурван өндөрлөг бүхий тогтолцоо биш, таван толгойтой, хариуцлагагүй систем бий болсон. Үүний хор уршиг нь Монгол төр хүчгүйдэх, муу хууль батлах, тэр нь нийгмийн хөгжилд чөдөр тушаа болох, байгалийн баялаг цөлмөгдөх, Монголын шүүх эрх мэдлийн байгууллага улс төрийн хараат болох байдлаар илэрч байгаа юм.

Үнэндээ бол Улсын УИХ-ын гишүүн нь Засгийн газрын гишүүн байдаг гаж тогтолцоо хууль тогтоох, гүйцэтгэх засаглалыг улам ойлгомжгүй болгож ирлээ. Иймээс хувийн ашиг сонирхлоо ард түмнээс дээрд үзсэн гэмт бүлэглэлүүд бий болж, шударга бус байдал газар авсан. Хуулийн байгууллагын удирдлагууд улстөрчдийн томилгоогоор, тэдний утсан хүүхэлдэй болж явдаг болсноор хуулийг дээдэлж хэрэгжүүлэх биш, тэр хүмүүсийнхээ хандлагыг дагадаг болсон.

Жишээ нь, саяхан хуульд орсон өөрчлөлтүүдийг би зөв талаас нь харж дэмжиж байгаа. Улс төрийн хараат хуулийн байгууллагуудыг улс төрийн хараат бус болгох анхны алхам хийгдлээ. Одоо Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулж хуулиа улам боловсронгуй болгох хэрэгтэй.

▶ 4

TDB
ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

МЭДЭГДЭЛ

Өнгөрсөн өдрүүдэд цахим сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан Худалдаа, хөгжлийн банкны удирдлагын талаар эх сурвалжгүй, худал мэдээллүүдийг санаатайгаар олон нийтэд тодорхой цаг хугацааны давтамжтайгаар цацаж байна.

Худалдаа, хөгжлийн банк нь Монгол улсаас Олон улсын зах зээлд бонд амжилттай гаргасан Монгол улсын хамгийн анхны аж ахуйн нэгж, цорын ганц арилжааны банк бөгөөд нийтдээ 5 удаагийн бондыг амжилттай гаргаж, тухайн бондуудаа цаг хугацаанд нь амжилттай эргүүлэн төлж харилцагчид, хөрөнгө оруулагчдынхаа итгэлийг алдалгүй, бизнесийн үүргээ хариуцлагатай биелүүлж байгаа. Мөн олон улсын хөрөнгө оруулагчдын дунд Монгол улсын банк санхүү, бизнесийн салбарын нэрийн хуудас болсон банк гэдгээ нэр төртэйгээр харуулж ирсэн.

Худалдаа, хөгжлийн банкны Гүйцэтгэх захирал О.Орхон нь Олон улсын зах зээл дээрээс 6 дахь удаагийн буюу 5-н жилийн хугацаатай 300 сая ам.долларын бонд арилжаалах албан томилолттой явж байгаа. Энэхүү арилжаа нь амжилттай хийгдсэнээр, Монгол улсад орж ирэх гадаадын хөрөнгө оруулалт буурч байгаа энэ үед Монгол улсын валютын нөөцийг нэмэгдүүлж, төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хадгалах болон эдийн засгийн өсөлтийг дэмжихэд жинтэй хувь нэмэр оруулах юм. Энэ чухал ажлыг гүйцэтгэж буй цаг мөчид санаатайгаар Худалдаа, хөгжлийн банкны бизнесийн нэр хүндэд халдаж, энэ ажлыг унагах, саад болох гэсэн оролдлого, мэдээллүүдийг зохион байгуулалттайгаар олон нийтэд цацаж байгаад гүнээ харамсаж байна.

Иймд, Худалдаа, хөгжлийн банкны болон удирдлагын талаар огт үндэслэлгүй худал мэдээллийг олон нийтэд түгээж, тус банкны нэр хүндэд ноцтойгоор халдаж буй нэр бүхий, бүртгэгдсэн хуулийн этгээдүүдийг энэхүү хууль бус үйлдлээ даруй зогсоохыг шаардаж, эдгээр хууль бус үйлдэлтэй холбогдох хууль, хяналтын байгууллагуудтай хамтран банкны зүгээс хатуу тэмцэхээ үүгээр мэдэгдэж байна.

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

2019.05.23

АЛТ	ЗЭС	10-ЧИНГИС БОНД	ХУРАЛДАЙ БОНД	ГЭРЭГЭ БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ
1275.38 2.04%	5928 1.13%	98.700 0.13%	110.70 0.12%	99.330 0.12%	2647.34	382.85	41.07

Улс төр

Ерөнхийлөгч Х.Баттулга УИХ-ыг тарахыг дахин шаардлаа

УИХ-ын гишүүд ард түмний төлөөлөл байх ёс зүйн чадамжаа үндсэндээ алдаад байна

Б.Сэлэнгэ
ЗГМ



С.Батсайхан / ЗГМ©

УИХ-ын 49 гишүүн ЖДҮХС-гийн хөрөнгөөс жилийн гурван хувийн хүүтэй зээлийг нэн хөнгөлөлттэй нөхцөлөөр өөртөө авсан, өөрсдийн эрх ашигт нийцүүлэн өөрчлөх замаар гэмт этгээдүүдийг “хөөн хэлэлцэх хугацаа дууссан” гэх нэрийдлээр хуулийн хариуцлагаас мулталсан, хүчин, хүн амины хэрэгт нэр холбогдох, авилгын гэмт хэрэгт сэрдэгдэх нь улам бүр даамжирч УИХ-ын гишүүд ард түмний төлөөлөл байх ёс зүйн чадамжаа үндсэндээ алдаад байна гэж үзээд УИХ-ыг өөрөө тарах саналыг Ерөнхийлөгч Х.Баттулга дахин гаргалаа.

Тэрбээр хагас жилийн өмнө мөн УИХ-ыг өөрөө тарах санал гаргаж байсан юм. Харин энэ удаа “...Наад зах нь Төрийн ордны тухай хуулийн заалтуудыг ноцтойгоор зөрчиж, албан тасалгаандаа согтууруулах ундаа хадгалах, хэрэглэх байдал даамжирснаас эрдэнэт хүний амь сүйдэх нөхцөл ч үүсжээ. Та бүхний батлан гаргасан Татварын багц хуульд хүний эрх, эрх чөлөөг хясан боогдуулах зүйл, заалт өчнөөн олноор орсон. Сангийн сайд нь өөртөө шүүх эрх мэдлээс давсан олон боломж гаргасан, бизнес эрхлэгчдийн өмчлөх, чөлөөтэй зорчих эрхэд халдсан, иргэншлийн ололт болсон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн суурь зарчмыг эвдсэн олон заалтыг бусдын нөлөөлөлд автсан байдлаар оруулсныг УИХ асар хайхрамжгүйгээр, хянан үзэлгүйгээр баталлаа” гэв.

Тэрбээр хагас жилийн өмнө мөн УИХ-ыг өөрөө тарах санал гаргаж байсан юм

Тиймээс ёс зүйгүй явдал, увайгүй хандлагын үлгэр жишээ болсноос бус, ард олныг итгүүлэн үнэмшүүлэх, сайн сайханд манлайлан дагуулах чадваргүй болсон УИХ-ыг өөрөө тарахыг уриалж байна гэдгийг Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга онцоллоо. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» ШҮҮХ
ТЕГ-ын даргаар ажиллаж байсан, Хошууч генерал Б.Хурцыг өнгөрсөн дөрөвдүгээр сарын 23-ны өдөр Чингэлтэй дүүргийн шүүхийн шийдвэрээр 461 дүгээр ангид саатуулж байсан юм. Түүнийг хорьж шалгах хугацаа өчигдөр дууссан тул үргэлжлүүлэн хорих эсэхийг шүүх хэлэлцээд суллах шийдвэр гаргажээ. Тэгэхдээ хорьж шалгах үндэслэл бүхий нотлох баримт байхгүй гэж үзсэн байна.

» ЗАСГИЙН ГАЗАР
Ерөнхий сайд У.Хүрэсүх зургадугаар сарын 1-нээс эхлэн хүсэлт гаргасан хүүхэд бүрт мөнгөн тэтгэмж олгох үүргийг өгсөн талаар Засгийн газрын хэвлэлийн албанаас мэдээлсэн. Тэгвэл ЗГХЭГ-ын дарга Л.Оюун-Эрдэнэ үүнийг үгүйсгэлээ. Тэрбээр “Ерөнхий сайдын зүгээс хүссэн хүүхэд бүрт хүүхдийн мөнгө олгох нь зүйтэй гэдэг чиглэл өгсөн. Улсын төсөвт суулгаж байж хүссэн хүүхдэд хүүхдийн мөнгө олгох боломжтой” гэв.

» ХҮСЭЛТ
Дамирангийн Энхбат агсантай холбоотой хэргийг улсын нууцаас гаргах хүсэлтийг ТЕГ-ын дарга асан Б.Хурцын эхнэр Ү.Сарнай гаргажээ. Тэрбээр энэ хүсэлтээ Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд, УЕП, ТЕГ-ын дарга зэрэг албан тушаалтанд хүргүүлсэн байна.

НАМУУД

Д.Эрдэнэбат: 2020 оны сонгууль руу чиглэсэн үйл ажиллагаа эхэлж байна

Б.Энхжаргал
@enkhjrglZGM

УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбатыг прокуророос яллагдагчаар татах тогтоолыг АТГ-т ирүүлжээ. Уг тогтоолтой тэрбээр танилцсан талаараа хэвлэлийнхэнд мэдээлэл өгсөн юм.

“Эрдэнэт” үйлдвэрийн 49 хувийг ОХУ-ын “Ростех” компаниас худалдан авсантай холбогдуулан түүнийг яллагдагчаар татсан аж.

Тэрбээр хэлэхдээ “АТГ надаас гэрчийн мэдүүлэг авсан. Дараа нь маш шуурхай яллагдагчаар татах тухай прокурорын 75 тоот тогтоол гарсан. Иргэнийхээ хувьд энэ тогтоолтой хууль журмын дагуу танилцаж гарын үсэг зурлаа. Гэтэл өчигдөр мөрдөн байцаагчтай уулзаж тогтоолтой танилцсаны дараа хэвлэлээр ялын үндэслэл, яллагдагчаар татсан тухай эх сурвалж нь тодорхойгүй мэдээлэл тархсан. Эрүүгийн хуульд аливаа нэгэн мэдээллийг өгөхдөө прокурорын зөвшөөрөл өгөх ёстой. Би ч бас иргэнийхээ хувьд уг асуудлыг хуулийн дагуу, ямар нэг улс төргүйгээр, олон нийтэд дулиан дэлгэхгүйгээр асуудалд хандаж ирсэн. Гэтэл яагаад процесс хуулийн дагуу явж байхад эх сурвалжгүй, үндэслэлгүй мэдээллийг зорилготой тараах болов гэдэг нь анхаарал татаж байна. Яг тэр өдрийн болсон үйл явдлыг ажиглаад харж байхад Л.Оюун-Эрдэнэ сайд Хөгжлийн банкны асуудлаар, мөн энэ хэрэгтэй холбоотой асуудлаар, Ч.Хүрэлбаатар сайд “Эрдэнэт”-ийн 49 хувьтай холбоотой асуудлаар нийтэд мэдээлэл хийсэн. Энэ бүгдийг уялдуулаад харахад улстөржсөн шинж агуулагдаж байна гэх дүгнэлтэд хүрч байна. Тийм учраас би өнөөдөр АТГ-ын дарга, Ерөнхий прокурорын газарт хүсэлт хүргүүлж байгаагаа албан ёсоор мэдээлж байна” гэлээ.

С.Батсайхан / ЗГМ©

Хүсэлтэд Эрүүгийн хянан шийдвэрлэх тухай хуульд хэрэг бүртгэл мөрдөн байцаалтын материалыг прокурорын зөвшөөрснөөр прокурорын мэдэгдэх бололцоотой гэсэн хэмжээгээр нийгэмд мэдээлж болно гэсэн заалтыг ноцтой зөрчсөн байна. Иймд Эрүүгийн хянан шийдвэрлэх тухай хуулийг зөрчиж хэрэг бүртгэл мөрдөн байцаалтын шатанд байгаа хэргийн талаар олон нийтэд мэдээлсэн явдлыг хяналтдаа авч шалгаж өгнө үү хэмээжээ. Түүнээс гадна АТГ-ын дарга З.Дашдаваад “Яг энэ үндэслэлээр зөвшөөрөлгүйгээр хууль зөрчин олон нийтэд эх сурвалжгүй мэдээлэл дэлгэн улстөржсөн үйл ажиллагаа явуулсныг анхааралдаа авна уу” гэсэн хүсэлт дахин явуулж байгаа гэв.

Харин “Эрдэнэт” үйлдвэрийн 49 хувийг Монголын компани худалдан авсан тухайд тэрбээр “Эрдэнэт”-ийн 49 хувийн худалдан авалт Монгол Улсад ямар ч хохирол авчраагүй. Гэтэл онц ноцтой хохирол учруулсан мэт худал үндэслэл гаргаж байгаа нь буруу. Үүгээр “Эрдэнэт” үйлдвэрт өмнө нь гардаг байсан хулгай луйврын хэргийг хаацайлах оролдлого хийж байгаа мэт харагдаж байна. Өнөөдөр нийгэмд байгаа үнийн хөөрөгдөл, архидалт, гэмт хэрэг, өвчин зэрэг асуудлыг намжаах гэсэн арга болжээ” гэв. [ЗГМ]

ЭШЛЭЛ

-Тухайн өдөр би 18.00 цагт чуулганы хуралдаан тараад, өрөөндөө хүмүүстэй уулзчихаад гарсан. Тэгэхдээ хүн газар унасан байхтай таарсан. Би хуульч хүн, ялангуяа 20 гаруй жил Эрүүгийн хэргийн хавтаст хэрэг, материалуудтай танилцаж байсан хүний хувьд авах ёстой арга хэмжээ нь юу вэ гэдэг утгаар зохих арга хэмжээг авсан.Төрийн ордон бол хуультай, хуулиараа төрийн тусгай хамгаалалтын газар нь ТЕГ-ын харьяанд байдаг. Тиймээс тус байгууллагын зохих удирдлагуудад мэдэгдсэн. 103 ирээд, “амь насаа алдсан байна” гэдэг дүгнэлт гаргасан учраас нөхцөл байдлыг баримтжуулан, фото зургийг цагдаагийн газарт хүлээлгэн өгсөн.

УИХ-ын гишүүн
О.Баасанхүү

[ЗГМ СОНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Ерөнхий эрхлэгч
Баатарын ДУЛАМХОРЛОО

Зөвлөх
Шатарбалын ДАВААДОРЖ

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба
Эдитор Б.Энхжаргал
Утас: 99901621

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Утас: 99903581
99903578
99907843

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайваны өргөн чөлөө,
“Блю Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар. 1024
Утас: 70103131,
Факс: 7010606

ЦАХИМ ХУВИЛБАР

zgm.mn
ubinfo.mn
Дугаарын удирдагч
Л.Сгуармаа

8 658000 029112 001150

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019.05.24-ний өдөр

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: XII.1.1.336 “Цэцэрлэгийн барилга, 200 ор /Хэнтий, Норовлин сум /” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер.
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: ТӨБЗГ-2019/ XII.1.1.336

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос: **XII.1.1.336 “Цэцэрлэгийн барилга, 200 ор /Хэнтий, Норовлин сум /”**, ажлыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000.00 (Тавин мянга) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх шаардлагатай.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.Үүнд:

- Сүүлийн 3 жил буюу 2016, 2017, 2018 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 30 хувиас багагүй байна.
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байна.
- Сүүлийн 3 жил буюу 2016, 2017, 2018 онуудын аль нэг жилд батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 30 хувиас доошгүй хэмжээний ижил төстэй барилга угсралтын ажлыг доод тал нь нэг удаа ерөнхий гүйцэтгэгчээр ажиллаж улсын комисст хүлээлгэн өгсөн байна. Гэрээ болон ажил хүлээлгэж өгсөн улсын комиссын актыг хавсаргана.

Дараах тусгай зөвшөөрөл шаардлагатай:

Зураг төсөл боловсруулах байгууллага нь :

- ЗТ-2.1. Архитектур, барилга бүтээц, барилгын зохион байгуулалтын зураг төсөл(БЗБТ,АГТ, ҮЗБТ)
- ЗТ-6.1. Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл
- ЗТ-6.3. Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл
- Орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл /КИП/, автоматикийн зураг төсөл
- ЗТ-6.4.Барилга байгууламжийн дотор радио холбоо, галын болон бусад дохиоллын систем, мэдээллийн байгууламжийн зураг төсөл, хамгаалалтын систем, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, компьютер хангамжийн дотоод сүлжээ, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл

Барилга угсралтын ажил гүйцэтгэх байгууллага нь:

- БА-2.1 Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил
- БА-6.1. Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт
- БА-6.2. Барилгын барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт
- БА-6.3. Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт,
- БА-6.4. Барилга байгууламжийн дотор холбоо дохиолол, интернэт сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт.
- БА-8.1. Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил

Тендерийн баталгааны дүн: 21,000,000.00 (хорин нэгэн сая) төгрөг. Монгол Улсын хуулийн этгээд тендерийн баталгааг банкны баталгаа, Монгол Улсын Засгийн газрын бонд, эсхүл Монгол Улсын Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр ирүүлж болно.

Тендерийн материалд цахим тендерийн баталгааг хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим систем тендерийн баталгаа гаргагч арилжааны банкны мэдээллийн сангаас тендерт оролцогчийн тендерийн баталгааны талаарх мэдээллийг шалгана.

Тендерийг 2019 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 10.30 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 11.00 цагт нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зохион байгуулдаг цахим худалдан авах ажиллагааны төлбөргүй сургалтад хамрагдахыг зөвлөж байна.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг,
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР,
Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1 дүгээр хороо,
Энхтайваны өргөн чөлөө-16А, Засгийн газрын IX байр,
Нэг цэгийн үйлчилгээ, Утас: 92263014, 92263435
Цахим хаяг: www.tender.gov.mn

Нийтлэлчийн булан

Гэмт хэрэг хамгийн их гардаг орнуудын жагсаалтын 21-д Монгол бичигдэж байна

Цөхөрч туйлдсан иргэдийн эцсийн сонголт гэмт хэрэг болов уу

С.Батсайхан / ЗГМ©

◄1

Гэхдээ энэ нь тус улсын эрх баригчдаас шалтгаалсан, харин хэдхэн жилийн дотор олон сая хүн улсаасаа дүрвэн явсантай холбоотой болохыг судлаачид онцлов. Мэдээж хүн амын тоо багасахын хэрээр гэмт хэрэг буурна л даа. Олон улсын судалгаанаас харахад гэмт хэрэг, зөрчлийн тоо нэмэгдэх үндсэн шалтгаан нь ажилгүйдэл, түүнийг даган бий болж буй ядуурал, эдийн засгийн уналт, улс төрийн нөхцөл байдал, өрхийн орлого, боловсролын түвшин болдог. Товчхондоо бол ард иргэд нь ядуурч, амьжиргааны түвшин доройтож, уур бухимдал нэмэгдэх тусам гэмт хэргийн гаралт өсдөг зүй тогтолтой аж.

Алс холын Венесуэл улсад ажиглагдсан энэ зүй тогтлыг Монголын хөрсөн дээр буулгаад нэг харвал ямар вэ. Цагдаагийн ерөнхий газар 2006 оноос хойш гэмт хэргийн статистик мэдээллийг өөрийн вэб сайтад байршуулж, олон нийтэд нээлттэй мэдээлдэг болсон. Статистик мэдээллийг харвал гэмт хэрэг жилээс жилд өссөөр байгаа аж. Жишээлбэл, улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоо 2016 онд 27167, 2017 онд 32259, 2018 онд 36220 гэх мэтээр дандаа өссөн үзүүлэлттэй байна. 2018 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн хүнд гэмт хэргийн тоо 8125 байгаа нь 2017 онтой харьцуулахад 20.4 хувиар нэмэгдсэн дүн болов. Энэ мэтээр хулгайн хэрэг 8.9 хувь, халаасны хулгай 46.6 хувь, дээрэм 21.4 хувь, залилан 79.3 хувь, малын хулгай 21.6 хувь, бусдын хөрөнгө завших хэрэг 52.3 хувиар тус тус нэмэгджээ. Нийтлэлийн эхэнд дурдсан гэмт хэрэг хамгийн их гардаг улс орнуудын жагсаалтын 21-д Монгол бичигдэж байгааг энд сануулъя. Манайх далайн дээрмээрээ зартай Сомали, мөнхийн дайн байлдаантай байдаг Ливи зэрэг улстай зуузай холбон 59.76 оноо авчээ.

Сонирхолтой нь гэмт хэргийн гаралтын тоо ядуурлын түвшинтэй шууд холбогдож байна. Манай улсын ядуурлын түвшин 1995-2007 онд 36.3 хувиас 29.3 хувь болж, аажмаар буурсан байна. Гэтэл 2009-2010 оны үед 38.7-38.8 хувь болж, эрс нэмэгджээ. Ядуурлын түвшин 2014 онд 21.6 хувьд хүрсэн нь ойрын жилүүдийн оргил "амжилт". Энэ үед гэмт хэргийн тоо ч харьцангуй цөөн байсныг статистик үзүүлэлтүүд баталдаг. Гэвч 2016 онд ядуурал 30 хувьд хүрч, үүнээс хойш буураагүйгээр барахгүй улам нэмэгдсээр байна. Чухам энэ үед гэмт хэргийн гаралт эргэн өссөн нь санамсаргүй тохиолдол яавч биш.

Гэмт хэргийн гаралтын тоо ядуурлын түвшинтэй шууд холбогдож байна

Сүүлийн үед төр засгийн хаалган бодлого, шийдвэрийн уршгаар иргэдийн амьжиргаа яаж доройтож байгаа нь нүдний өмнө илхэн байна. Төрөл бүрийн татварын хувь хэмжээ ойр ойрхон нэмэгдсэнээс гадна тэтгэврийн насыг үе шаттайгаар нэмэхээр болсон нь олон нийтийг бухимдуулж байгаа. Ядаж байхад яр гэгчээр авсан цалингаа амьдралдаа хүргэх гэж зүдэрч яваа олныг өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт улам нэрвэв. Өмнө нь яснаас өөр юмгүй гэж голдог байсан нөөцийн мах одоо ховрын бараа болчихлоо. 6000 төгрөгийн нөөцийн мах авах гэж иргэд хэдэн цагаар дугаарлан зогсож, 1990-ээд оны картын барааны үе шиг алалцаж байгааг харахад л олон нийт ямар ядруу амьдарч байгаа нь шууд ойлгогдоно. Иргэд нь иин ядуурч, ажил олдохгүй, цалин нь хүрэхгүй зүдэрч байхад төрийн түшээд асар бага хүүтэй зээлийг тэрбум тэрбумаар нь хуйвалдан авч олон "ЖДҮ"-чин илрэн, олныг улам бухимдууллаа. Тэр байтугай эх үүсвэр нь тодорхойгүй "Итгэлийн зээл" барьцаа хөрөнгөгүйгээр олгоно, та бүхэн минь өргөнөөр аваарай гэж тохуурхах. Ямар нийгэмд амьдраад байна даа гэж хааяа бодогдох юм.

Уурлаж бухимдсан хүмүүс, аргаа барсан олон нийт болчимгүй алхам хийх зам руу халтирдаг нь гэмт хэргийн тоо өссөн статистикаас харагдана. Ядуурал хүн амын гүнд нэвчих тусам гэмт хэрэг тоо нэмэгдэж, нөхцөл байдал хүндэрдэг нь зөвхөн Монгол гэлтгүй дэлхий нийтэд тохиодог зүй тогтол аж.

Тэгэхээр гэмт хэрэг их гараад байна гээд шоронгийн хүртээмжийг нэмэх нь чухал биш юм. Ялын бодлогыг чангаруулж, аль болох олон хүнийг аль болох удаан хугацаагаар шоронд хатаах бүр ч буруу. Гэмт хэрэг дийлдэхээ болилоо гээд цагдаа, хүчний байгууллагын орон тоог нэмэгдүүлэх нь ч оновчтой шийдэл биш. Зүгээр л төрийн эрхэнд байгаа нөхдүүд улсаа олигтойхон удирдаад, хүн амынхаа амьжиргааг сайжруулаад, орлогын эх үүсвэрийг нь нэмж, ажлын байраар хангаж, бизнес эрхлэгчдээ дарамталж, боомилолгүй эдийн засгийн эрүүл орчныг бий болговол л гэмт хэрэг аяндаа буурна. Ажилтай орлоготой, амьдрал ахуй нь тэгширсэн хүн юу дутлаа гэж гэмт хэрэг хийж, өөрийгөө болон өрөөлийг эрсдэлд оруулах билээ. [ЗГМ]

2018 БОЛОН 2019 ОНЫ ЭХНИЙ ДӨРВӨН САРД БҮРТГЭГДСЭН ЗАРИМ ГЭМТ ХЭРГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

	2018	Өсөлт	2019
ХҮН АМИНЫ ХЭРЭГ	58	25.9%	73
ХҮНИЙГ АМИА ХОРЛОХ НӨХЦӨЛ БАЙДАЛД ХҮРГЭХ	265	17%	310
ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ	114	65.8%	189
БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ	224	54.5%	346
ХҮЧИНДЭХ	193	12.4%	217
МАЛЫН ХУЛГАЙ	368	76.1%	648
МАНСУУРУУЛАХ БОДИС ХУУЛЬ БУСААР АШИГЛАХ	75	38.7%	104
АВЛИГА	11	14.2 дахин	156

С.ЦОГТБАЯР ЗУРЖ БАЙНА

ДОКТОРЫН ЗЭРЭГ ХАМГААЛНА

МУИС-ийн Философи, шашин судлалын тэнхимийн докторант Самбидын Хишигтогтох "Ухамсаргүйн тухай З.Фрейдийн үзэл соёлын генеалогид холбогдох нь" сэдвээр философийн докторын (Ph.D) зэрэг хамгаална. Хамгаалуулах зөвлөлийн хурал 2019 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 10:00 цагт МУИС-ийн хичээлийн I байрны "Дугуй танхим"-д болно. Горилогчийн бүтээлтэй МУИС-ийн Номын сангаас танилцана уу.

Философийн докторын зэрэг хамгаалуулах зөвлөл

Цаг үе

"Алиби" бол дэлхий нийтээр бүх улс оронд хүлээн зөвшөөрөгдсөн пакт

Өмгөөлөгч хүн эмч хүнтэй ижил. Эмч хүн хэнийг ч эмчлэхийн төлөө явдагтай адил өмгөөлөгч бол тийм л үйлчилгээг үзүүлдэг бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн субьект.

Ц.Монгол: Монголынхоо баялгийг сорчилж, ухаж төнхөөд байгаа нөхдүүдийг өмгөөлөх дургүй

◄1

Хоёр танхим бүхий хяналтын тогтолцоотой, шинэ парламент бүхий Үндсэн хуулийн шинэ тогтолцоогоор явахын бол зөв болно л гэж боддог. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Зөвлөмжөөр хуулийн байгууллагын нөхдүүдэд хариуцлага тооцсон нь харин ч хариуцлагын тогтолцоог бий болгож байгаа хэрэг. Энэ талаас нь харвал яах аргагүй зөв шийдвэр болж байгаа юм.

-Та сүүлийн үед ямар компанид өмгөөллийн үйлчилгээ үзүүлж байгаа гэсэн бэ?

-Эрдэнэтийн балансын бус хаягдал овоолгоос зэс үйлдвэрлэж байгаа "Ачит-Ихт" компани.

-Тус компанийн тухай хэр сайн мэдэх вэ?

-Төсвөөс нэг ч төгрөгийн санхүүжилт авалгүй, Хөгжлийн банк, бондны мөнгөнөөс зооголчихолгүй, дотоод, гадаадын банк, хөрөнгө оруулагчаас арилжааны зээл авч, үлдсэн санхүүжилтээ бүтээгдэхүүн худалдаалах гэрээгээр шийдсэн үндэсний компани юм байна лээ. Миний хувьд энэ компанийн гэрээт зөвлөхөөр ажилладаг учраас бодит мэдээлэлд илүү ойр байгаа.

-Ашгүй дээ. Тэгвэл таниас нэг зүйл асууя. "Ачит-Ихт" ХХК-ийг Ерөнхийлөгч асан Ц.Элбэгдоржтой холбоотой гэсэн хардлага байдаг. Энэ үнэн үү?

-Энэ компанийг Ерөнхийлөгч асан Ц.Элбэгдоржтой холбоотой мэтээр харддаг. Хуульч, өмгөөлөгч мэргэжилтэй хүний хувьд, бас гэрээт зөвлөхийнхөө хувьд сонирхож үзэх боломж гарсан л даа. Үнэнийг хэлэхэд "Ачит-Ихт" компани тэр хүнтэй ямар нэгэн холбогдолгүй юм байна лээ. Үүнийг харин би итгэл үнэмшилтэй, хариуцлагатайгаар хэлж чадна.

-Та үйлчлүүлэгчийнхээ ямар асуудал дээр өмгөөлөл үзүүлж байгаа юм бэ. "Эрдэнэт" үйлдвэртэй холбоотой маргаан уу?

-Чамайг яагаад тэгж асууж байгааг мэдэхгүй юм. Сүүлийн үед энэ компанид 2011-2012 онд ганц жил гаруй ажиллаж байсан нэг хүн, тусгай сайт хүртэл нээчихээд энэ компанийн нэр төрд халдаж үндэслэлгүй мэдээлэл нийтэлж, үүсгэн байгуулагчийг нь дарамталж гүтгэлэг явуулж байгаа. Энэ хүнтэй уулзаж ярилцаж асуудлыг эвийн журмаар шийдэх гэж оролдсон боловч бүтэлгүй болсон ба одоо маргаан даамжирч байгаад хүнийхээ хувьд харамсаж байна. Харин "Эрдэнэт" үйлдвэртэй холбоотой ямар нэгэн маргаан байхгүй. Балансаас хасагдсан овоолго ашигласныхаа төлбөрт "Эрдэнэт" үйлдвэрт жил бүр роялти төлдөг юм байна лээ. Улсад одоо хүртэл 136 тэрбум төгрөгийн татвар төлсөн. Бүх үйл ажиллагаа нь хуулийн дагуу, гэрээ, ном журмынхаа хүрээнд явагдаж ирсэн байна.

-Хөдөлмөрийн гэрээтэй холбоотой маргаан уу?

-"Ачит-Ихт" компанид ажиллаж байгаад ажлаасаа өөрийн хүсэлтээрээ чөлөөлөгдсөн иргэний нэхэмжлэлтэй маргаан байгаа юм. Тус компанийн өмнөх гүйцэтгэх захирлын үед ажиллаж байгаад ажлаасаа өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөөд төрийн өмчит "Эрдэнэс Тавантолгой" ХК-д ажилд орсон юм байна лээ. Дараа нь "Эрдэнэс Тавантолгой" ХК-иас чөлөөлөгдөж ажилгүй болсон хойноо хуучин ажиллаж байсан "Ачит-Ихт" ХХК-иасаа үндэслэлгүйгээр мөнгө нэхэмжилж улмаар шүүхэд хандсан маргаанд үндэсний компанийн өмнөөс өмгөөлөл үзүүлж байгаа.

-"Ачит Ихт" компани ашигтай ажиллаж байгаа биз дээ. Нэхэмжилсэн мөнгийг нь өгчихгүй яасан юм бол?

-Өгөх ёсгүй болоод л өгөхгүй байгаа хэрэг л дээ. Бүх юм хуулийн дагуу байх ёстой шүү дээ. Тэгээд ч тус компанийнхан нэг хүний төлөө биш, нийтийн, нийгмийн мөрөөдлийн төлөө зүтгэж, ажиллаж хөдөлмөрлөж байгаа гэсэн итгэл үнэмшилтэй байдаг хамт олон юм билээ. "Ачит-Ихт" компани гидрометаллургийн үйлдвэрийнхээ ТЭЗҮ-ийг Бээжингийн Уул уурхай металлургийн институцээр 2011 онд анх хийлгэсэн байгаа юм. Мөн 2011 онд "Эм Ки Эс" ХХК-иар зураг төсөл хийлгэх гэрээ байгуулж байсан төдийгүй, 2012 онд ижил төстэй "Эрдмин" ХХК-ийн захирал профессоруудаар ТЭЗҮ-ээ хийлгэж байсан юм байна. 2011-2014 он хүртэл 150 гаруй монгол инженер техникийн ажилчдын хөдөлмөр, одоо ажиллаж байгаа 220 ажилчны хичээл зүтгэл гээд чамгүй хүний нөөцтэй шүү дээ.

Гэтэл энэ их олон хүний хөдөлмөрөөр бүтсэн "Ачит-Ихт" ХХК-ийн гидрометаллургийн үйлдвэрийг тус үйлдвэрт 2011-2012 оны хооронд жил гаруйхан хугацаанд ажиллаж байсан автын инженер мэргэжилтэй, иргэн С.Цэвэгжав гэгч "Ямар ч зураг төсөлгүй үйлдвэрийг би зураг төслийг нь гаргаад босгочихсон юм" хэмээн худал мэдээлэл тарааж, элдэв шантааж үзүүлсээр ирсэн байдаг. Тэр хүн 2010 оны 12 дугаар сараас 2012 оны 5 дугаар сарын 1 хүртэл үйлдвэрт ерөнхий инженер хийж байгаад өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж, "Эрдэнэс Тавантолгой" ХК-д ажилд орсон юм байна.

"Ачит Ихт" ХХК-ийн өмнөх гүйцэтгэх захиралтай хуйвалдаж, ТУЗ-ийн зөвшөөрөлгүйгээр 2012 оны 5 дугаар сарын 1-нээс 12 дугаар сарын 31 хүртэл төслийн зөвлөх гэсэн тушаалыг гаргуулж, "Эрдэнэс Тавантолгой" компанид ажиллаж байхдаа Ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль, Хөдөлмөрийн хуулийн заалтуудыг зөрчиж "Ачит-Ихт" ХХК-иас давхар цалин авдаг байж.

Тэгээд 2017 онд "Эрдэнэс Тавантолгой" ХК-иас гарч ажилгүй болсныхоо дараа дээрх тушаалаа ашиглаж Орхон аймгийн Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд харъяаллын бусаар хандсан л даа. Тэр хүн нэхэмжлэлдээ 2010-2012 оны хооронд "Ачи-Ихт" ХХК-д Ерөнхий инженер болон Барилгын зөвлөх үйлчилгээ давхар эрхэлж байсан болохыг тогтоож өгөхийг хүссэн байна. Түүний ажилд орсон, ажлаас чөлөөлөгдсөн тушаалууд нь бүрэн байхад тэрээр шүүхэд хандсан, шүүх хариуцагч нь байсаар байхад мэдэгдэлгүйгээр иргэний хэрэг үүсгэсэн нь хачирхалтай. Харамсалтай нь механик инженерийн сургууль төгссөн, автын инженер С.Цэвэгжавыг 2012 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл төслийн зөвлөх буюу барилгын зөвлөх үйлчилгээг давхар эрхэлж байсан гэж Орхон аймгийн Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Н.Үүрийнтуяа шийдвэрлэсэн.

-Энэ шийдвэр та бүхэнд таалагдаагүй хэрэг үү?

-Шүүхийн шийдвэр хүн бүрт таалагдах албагүй л дээ. Хамгийн гол нь хэд хэдэн хууль зөрчсөн хууль бус шийдвэр болсон. Хэрэглэх ёстой хуулийг хэрэглээгүй байгаа юм. Хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн. Жишээ нь, Барилгын тухай хуульд заасан барилгын зөвлөх үйлчилгээ үзүүлдэг этгээд хэн бэ? Барилгын зөвлөх үйлчилгээ үзүүлдэг этгээдэд зөвлөх үйлчилгээний эрхийг хэрхэн олгодог вэ? Барилгын яамнаас баталсан дүрэм журам заавар, барилгын хуулийг хэрэглээгүй. Гол нь, шүүх "автын механик хүн барилгын зөвлөх үйлчилгээ үзүүлж болно оо" л гэсэн хачирхалтай дүгнэлт хийсэнд л байгаа юм. Шүүх хүссэнээрээ л асуудалд хандаж, ямар ч үндэслэлгүйгээр хэн нэгэнд бусдаас мөнгө нэхэмжлэх эрх үүсгэж өгч байгаа хэрэг л дээ. Хөдөлмөрийн тухай хуульд "Төрийн өмчит байгууллагад ажиллаж байсан этгээд өөр байгууллагад ажил эрхлэхгүй" гэсэн хуулийн заалт байдаг. Харьяаллын бусаар нэхэмжлэгч Орхон аймгийн Сум дундын иргэний хэргийн шүүхэд удаа дараа хандаад түүнийг нь шүүх хууль зөрчин хүлээж аваад л байдаг нь анхаарал татаж байна. Орхон аймагт үйл ажиллагаа явуулдаг "Ачит-Ихт" ХХК-д төслийн зөвлөх гэсэн тушаалыг зургаан сарын хугацаатайгаар хамтарч ажиллаж байсан хүнээрээ гаргуулаад тэрнийхээ дараа "Эрдэнэс Таван толгой" ХК-ийн дэд захирлаар очоод ажиллаж байсан хүн тэндээс энэ зургаан сарын хугацаанд давхар төслийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх ямар ч боломжгүй. Өөрөөр хэлбэл "алиби" буюу хөдөлмөрийн эрх зүйн харилцаа байхгүй, тухайн хүн ажил хийх ёстой газраа огт байгаагүй, өөр газар, өөр аймгийн алслагдсан нутагт өөр ажил эрхэлж байсан нь тогтоогдсон байхад, шүүгч "барилгын зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан" гэж тогтоосон нь байж боломгүй хадуурал, дур зоргоороо авирласан асуудал. Харамсалтай нь, ийм шүүгчдэд хариуцлага хүлээлгэх тийм хуулийн тогтолцоо боловсронгүй бус байна.

-"Алиби" гэсэн үү. Анх удаагаа л сонсож байна.Түүгээр юу илэрхийлнэ гэж?

-Хилсээр хүн амины гэх мэт хүнд гэмт хэрэгт холбогдоод цаазын ял авах гэж байсан хүн "Алиби" буюу тухайн гэмт хэрэг гарч байх тэр цаг үед өөр газар байсан нь тогтоогдвол түүний эсрэг ямар ч нотолгоо байсан ч гэсэн тухайн хүнийг энэ гэмт хэрэгт огт хамааралгүй гэж үздэг хуулийн зарчим. Өөрөөр хэлбэл Өмнөговь аймагт "Эрдэнэс Тавантолгой" ХК-д ажиллаж байсан этгээд энэ цаг үед Орхон аймагт ажиллах ямар ч боломжгүй. Иймээс энэ тохиолдлыг "Алиби" гэж үзэх болно. Энэ бол дэлхий нийтээр бүх улс оронд хүлээн зөвшөөрөгдсөн пакт. Тэгвэл, манай шударга ёсны бурхан эсрэгээр нь, бүр "барилгын зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан нь үнэн" гээд хүчээр тогтоочихож байгаа юм. Давж заалдах шатны шүүх нь бас энэ шийдвэртэй зууралдсаар байгаад хэвээр нь үлдээж байгаа нь ашиг сонирхлын зөрчилтэй "захиалгатай" гэх хардлагыг төрүүлж байна.

Шүүгчдэд хариуцлага хүлээлгэх хуулийн тогтолцоо боловсронгүй бус байна

-Өмгөөлөгч хүнд өөрийн гэсэн итгэл үнэмшил байдаг нь мэдээж. Бас их мэдрэмтгий ч болдог байх. Энэ маргаанаас та юу анзаарав?

-Өмгөөлөгч хүн эмч хүнтэй ижил. Эмч хүн хэнийг ч эмчлэхийн төлөө явдагтай адил өмгөөлөгч бол тийм л үйлчилгээг үзүүлдэг бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн субьект. Хэдийгээр хуулийн талаасаа өмгөөлөл үзүүлэх үүрэгтэй ч, Монголынхоо баялгийг сорчилж, ухаж төнхөөд байгаа нөхдүүдээс аль болох татгалзахыг л хичээдэг. "Ачит-Ихт" ХХК-ийн мэдээллүүдийг аваад судалж үзэхэд үнэхээр л эерэг итгэл үнэмшил төрж байсан. Яахав эвлэвэл бүтнэ ховловол гутна гэж үг бий. Мэдээж илүү дутуу мөнгө өгөх хууль зүйн үндэс байхгүй гэлээ ч, эвийн журмаар асуудлыг шийдвэл яасан юм бэ гэсэн саналыг аль аль талд нь тавьж, уулзуулж байсан ч харамсалтай нь эв зүйгээ олж чадаагүй. Адгийн зарга 10 хоног гэгчээр маргаан үүсээд л явж байна. "Ачит-Ихт" компанийн хувьд үндэсний үйлдвэрлэгч, ямар нэгэн бохир арга хэрэглээгүй, хуулийн хүрээнд балансын бус хаягдал овоолгыг ашиглаж боловсруулах гэрээгээ байгуулж, дотоодын банкнаасаа зээл аваад зээлээ ном ёсоор нь төлсөн баримтууд нь бүгд байж байгаа. Тиймээс би итгэл үнэмшилтэйгээр өмгөөлж байгаа. Зарим этгээдийн ярьж бичиж байгаа шиг "Манангийн толгойлогч" нартай холбоотой байсан бол би л лав өмгөөлөхгүй байсан.

-Хууль шүүхийн салбарт гарч буй алдаа завхралыг хараад ахмад өмгөөлөгч хүний хувьд хэр эмзэглэж байна вэ?

-Шүүхээр хүний эрх, компанийн эрх хууль ёсны эрх ашиг сонирхлыг зөрчиж шударга бус шийдвэр гаргаж байгаа тэр процессыг "хонгил" гэж нэрлээд байх шиг. Иргэний хэрэг дээр таньдаг шүүгчээрээ дамжуулан түүнд нөлөөлөөд хэргийг хууль бусаар шийддэг байдал ажиглагдаж байгаа бол, захиргааны хэргийн шүүх дээр ашигт малтмалын лиценцтэй холбоотой ч юм уу, улс орны язгуур эрх ашгийг зөрчөөд хууль бусаар өгчихсөн лицензүүдтэй холбоотой хэргүүдийг гадныханд ногоон гэрлээр шийдэж өгч байгаа тохиолдолууд байгаа. Эрүүгийн хэргийн хувьд бүр ч ноцтой жишээ олон байгааг та бүхэн надаар хэлүүлэлтгүй мэдэж байгаа шүү дээ.

-Та бас шүүгчээр ажиллаж байсан хүн, шүүгчээсээ татгалзчихаж болоогүй юм уу?

-Би 1991-1994 онд шүүгч хийж байсан. Тэр үед би хэргийн оролцогчдоос ямар нэг үл итгэх байдал ажиглагдмагц би өөрөө татгалзчихдаг байсан. Одоо бол их өөр дүр зураг харагдаад байна. Өөрөө татгалздаг шүүгч их ховор болсон. Гэхдээ тийм шүүгчид бол цөөн ч гэсэн байна. Энэ таны асуугаад байгаа хэргийн хувьд би шүүгчээс, шүүх бүрэлдэхүүнээс татгалзсан ч ерөөсөө татгалзлыг хүлээж аваагүй. Шүүх нэг хэрэг авсан бол ерөөсөө зууралдаад салдаггүй муу жишиг тогтчихсоны нэг амьд жишээ бол энэ. Энэ нь нэг бол ашиг сонирхлын зөрчилтэй, нөгөө бол нэхэмжлэгч этгээдтэй хувийн харьцаатай байж таарна аа даа. Ер нь тийм биз дээ. Сонирхолгүй бол шүүгч татгалзах хүсэлтийг хүлээн авах эсхүл өөрөө татгалзаад гарах л байсан шүү дээ. За ингээд Орхон аймгийн Сум дундын шүүхэд итгэх итгэл алдарсан тул нийт шүүгчдээс татгалзахаар компанид санал тавьсан боловч, компанийн удирдлага шүүх бүрэлдэхүүнд найдаж хүсэлт гаргаагүй. Ер нь бол, Орхон аймгийн Сум дундын иргэний хэргийн шүүхэд тодорхой хэмжээний нөлөө ороод шударга бусаар шийдвэр гаргаад явж байгаа нь бас нэг хонгил байхгүй юу. Нарийн ярих юм бол янз бүрийн хонгилууд байгаад байх шиг.

-Иргэний хэрэг дээр анхаарвал зохих ямар асуудлууд гардаг вэ. Таныг мэдэх ёстой хүний нэг гэж бодоод л асуучихлаа.

-Эрүү, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд завхралын шинжтэй олон арван заалтууд орсноор гэмт этгээдүүд, шударга бус этгээдүүдэд их ч боломж олгож, шударга иргэдийг ихээхэн хохироож байна. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд л гэхэд зөндөө олон заалт орсон. Жишээ нь, шинжээч томилуулахаар аль нэг тал хүсэлт гаргалаа гэж бодьё. Шүүгч тэрийг нь хүлээж авахгүй. Тусгай мэргэжил мэдлэг шаардаад шинжээчийн дүгнэлт гаргаад ирэхээр хэрэг нь зөв шийдэгдэх нотолгоо бий болдог. Гэтэл шинжээчийг томилохгүй байгаа тэр шүүгчийн шийдвэрт гомдол гаргах эрхийг хуулиар хязгаарласан. Энэ бол хүний эрхийг зөрчиж байгаа наад захын жишээ юм.

Манай хууль шүүхийн байгууллагын гажуудал хуульчиддаа байхаас гадна, хариуцлагын тогтолцоо байхгүй, халж сольдог заалт ч байхгүй, яг л хааныг бүх насаар нь өргөмжилдөг шиг шүүгчийг бүх насаар нь өргөмжилчихөөд, өргөсөн тангарагтаа үнэнч байж чадаагүй хууль зөрчсөн, ёс зүйгүй, нэг талд шийдвэр гаргадаг нөхдүүдэд сахилгын хариуцлага хүлээлгэдэг, ажлаас нь чөлөөлдөг тэр механизм байхгүй байгаатай холбоотой. Тиймээс зарим шүүгч буруу шийдвэр гаргаж, бусдыг хохироогоод хэл ам дагуулаад байна л даа .

-Өмгөөлөгч хүн үзэл бодол, хандлагаа нэгдүгээрт тавих ёстой байдаг юм уу, эсвэл үйлчлүүлэгчээ эхэнд тавих ёстой юу?

-Үйлчлүүлэгчийнхээ эрх, хууль ёсны эрх ашиг сонирхлыг дээдэлж, түүнд хуулийн хүрээнд эрх зүйн зөвлөлгөө туслалцаа үзүүлэх учиртай. Миний хувьд хэдийгээр хуулийн талаасаа өмгөөлөл үзүүлэх үүрэгтэй ч, Монголынхоо баялгийг сорчилж ашиглаж байгаа нөхдүүдээс аль болох татгалзахыг л хичээдэг.

Жишээ нь, "Ачит-Ихт" болон тэр компанид ажиллаж байгаад гарсан иргэний холбогдолтой маргаан дээр үйлчлүүлэгчийн эрх ашиг хохирч байгаа тул би уг үйлчлүүлэгчийнхээ олон нийтэд энэ талаар мэдээлэл өгөхийг хүссэн хүсэл, зоригийг хүндэтгэн зарим мэдээлэл хийсэн. Ер нь нийтийн эрх ашигтай холбоотой маргаантай холбогдох аливаа асуудлыг олон нийтэд ил тод мэдээлж ажилладаг ба энэ нь тухайн үйлчлүүлэгчийн хүсэл зоригийн дагуу л хийгддэг.

Үйлчлүүлэгч маань одоо Шүүхийн ёс зүйн хороонд нэгэнт гомдол гаргасан, энэ талаар мэдээлэл хийхийг хүссэн учраас энэ ёс зүйгүй, мэргэжлийн хариуцлагын санаатай алдаа гаргасан гэж үзэхээр шүүгчийн алдаа, үйл ажиллагааны талаар таны асуултад хариулж байгаа юм. Орхон аймгийн Сум дундын иргэний хэргийн шүүхийн шүүгч Д.Үүрийнтуяа үнэхээр хариуцлагагүй, ёс зүйгүй ажилласан. Тэр утгаараа ёс зүйн талаас нь ярьж байна. Төрөөс явуулж байгаа бодлогыг дэмжиж байгаа учраас хараат, ёс зүйгүй, хуулийг уландаа гишгэсэн, хуулийг буруу хэрэглэдэг, хэрэглэх ёстой хуулийг хэрэглэдэггүй нэр бүхий шүүгчдэд хариуцлага тооцох ёстой. Шударга хүн бол хэзээ ч юунаас ч айхгүй л байдаг байхгүй юу. Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж гараад ажлаа өгсөн ч тухайн шүүгч хууль зөрчөөгүй гэдгээ гурван шатны шүүхээр тогтоолгоод ажилдаа орох хуулийн зохицуулалт байгаа. Энэ бол боломжтой л асуудал шүү дээ. Дахин хэлэхэд Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжийг хууль, шүүхийн байгууллагуудын удирдлагуудыг өөрчлөхөөр хуульчилсан нь харин ч нэг удаадаа хариуцлагын механизмын эхлэл тавигдсан гэж бодож байна.

-Ярилцсанд баярлалаа. Танд эрүүл энх сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

-Баярлалаа. Тогтолцооны гажуудлаа засаад, шүүх эрх зүйн зохицуулалтаа сайжруулаад, шүүгчид нь хууль, ёс зүйгээ чандлан баримталдаг болчихвол засаг төр маань ч улам бүр саруулжих л болно шүү дээ.

ЗГМ: Сэдэв

Залуусын хөгжлийн бодлого залуургүй болсон

Залуусын хөгжлийн индексээр Швед, Норвег, ХБНГУ, Их Британи, Австрали улс "айргагдаж" монголчууд 183 орноос 71-д эрэмбэлэгдэж байна.

С.Батсайхан / ЗГМ©

Залуусын хөгжлийг дэмжих хуулийг хоёр жилийн өмнө баталсан ч мэддэг хүн тун ховор

Б.Гарьд
ЗГМ

Дэлхий нийтийн хөгжлийн үзүүлэлтээр манай улс "коммунизмын дараах орон" гэсэн өрөвдөм ангиллаас гарч амжаагүй л байна. Үүнээс салж дараагийн шатанд дэвшихийн тулд нийгмийн сэтгэлгээ, залуусын хөгжлийн түвшинг ахиулсан байх шаардлагатай. Гэвч залуучуудын хөгжлийн бодлого, төрөөс үзүүлэх дэмжлэгийг харвал бүр өрөвдөм зураглал тодорч байна. Хүн өөрийгөө хөгжүүлэхийн тулд өөрөө мэрийлт, хүчин чармайлт гаргаж амжилтад хүрэх нь маргашгүй. Гэхдээ төрөөс бодлогоор дэмжихгүй бол хөгжих боломж хязгаарлагддаг нь ардчилсан нийгмийн жам ёс. Манай залуус чөлөөт цагаараа өөрийгөө хөгжүүлье гэхэд очих газар, багтаж шингэх орчин, нөхцөл огт алга. Боловсрол, мэдлэгтээ шамдах гэхнээ 18 цагаас хойш ажилладаг номын сан ч байхгүй. Ийм нөхцөлд интернэт тоглоом, сошиал солиоролд автахгүйн тулд гадагшаа тэмүүлж, соёл, боломж өвөртлөхөөр зорих болсон. Төрөөс харж үзэх, халамжлан дэмжих бодлого дутсанаас гадагшаа явж байж л сэтгэлгээгээ бас өөрчлөх замыг сонгож байна.

Өнөөдөр залуусын хөгжил, төрөөс дэмжих бодлогыг Монголын залуучуудын холбоо гэх байгууллагын ажил мэтээр ойлгодог хүн дийлэнх олонх. Тэр байгууллага бол Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газартай хамтран ажилладаг 34 төрийн бус байгууллагын л нэг гэдгийг хэлээд өгчих буянтан алга. Ийм ойлголттой орны залуус яаж хөгжиж, улсынхаа ирээдүйг сайн, сайхан руу хөтлөх вэ.

Залуусын хөгжлийн индексээр Швед, Норвег, ХБНГУ, Их Британи, Австрали улс "айргадаж" монголчууд 183 орноос 71-д эрэмбэлэгдэж байна. Социализмын буян, Монголын хувьсгалт залуучуудын эвлэлийн (МХЗЭ) ачаар залуусаа хөгжүүлж байсны үр дүнд эхний 50-д жагсаж байсан бид жил ирэх тусам байр ухарсаар байгаа. Үүний гол шалтгаан нь нийгэм солигдсоноос хойш залуус руу чиглэх бодлогыг зөнд нь орхисны гор юм. 2016 оноос өмнө бүр залуучуудын хөгжлийн бодлого ч үгүй байв. Бодлогогүй учраас тэдний асуудлыг хариуцсан төрийн захиргааны байгууллага, хэрэгжүүлэх нэгж ч байсангүй. Яг үнэндээ манай төр валют цуглуулах зорилгоор залуусаа олон мянгаар нь гадаадад хар ажилтнаар илгээсэн шүү дээ. Ийм улс залуучуудын хөгжлийн бодлогоо нэг яамныхаа мухарт мартаж, өөрсдөөсөө ч нуухыг хичээж иржээ. Ертөнцөөс нуух аргагүйдээд эхлэхээр хүүхдийн төлөө газрын дэргэд нааж "дайвар" бүтэц бий болгож, өөрсдийгөө хуураад сууж байна. Угтаа манай улс залуусын орон мөн л юм бол залуучуудын хөгжлийг хариуцсан тусдаа бүтэцтэй баймаар. Тийм бүтцийг хуулиар тогтоомоор юм.

2016 оноос өмнө манай улс залууст зориулсан бодлого ч үгүй байв

2017 онд Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг баталсан нь олзуурхууштай ч 2018 онд хэрэгжиж эхэлсэн эл хуулийг мэддэг монгол залуу тун ховор. Монгол Улсад залуу хүн гэж хэдэн насны иргэнийг хэлэх вэ гээд асуухад мэддэг хүн бараг алга. Ийм хууль байдаг юм уу гэсэн сөрөг асуулт тавих нь элбэг. Хуулийн эхний заалт болсон 15-34 насны иргэнийг залуучууд гэж үзнэ гэсэн заалтаа мэдэхгүй байгаа хүмүүс нарийн ширийнийг мэдэхгүй байх нь зүйн хэрэг. Хариуцсан яам, байгуулсан бүтэц нь хуулийг хэрэгжүүлэх, сурталчлах ажлыг орхигдуулснаар шинэ хуулийг ширээний нүдэнд "булшилчихжээ". "Залуучуудыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг Засгийн газар нь дөнгөж өнгөрсөн долоо хоногт баталлаа. Тэр хөтөлбөрийг нь гадарлаж байгаа залуус бүр нүдний гэм юм. Дэлхий улам глобалчлагдаж, хүн төрөлхтний амьдрал улам хурдсаж буй өнөө үед ийм үлгэн салган, домносон байдлаар хөгжлийн араас гүйцэхгүй нь тодорхой. Тийм л учраас залуучуудын хөгжлийг залуурдах, төрийн бүтцийг бий болгох нь нэн чухал байна. Тэр бүтцийн хийх ажил ч "гудамжинд" овоорч, гадуур хөглөрсөөр.

Хэрэгжээд хэдийн жил хагасын хугацааг өнгөрөөсөн хуульд залуусын хөгжлийг дэмжих сайн сайхан заалт олон бий. Тухайлбал, залуучуудыг орлоготой нь нийцсэн уян хатан төлбөрийн нөхцөлтэй орон сууцаар хангах, залуу гэр бүлийг орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх, номын сангийн үйлчилгээг залуучуудад хүртээмжтэй болгох, гарааны бизнест нь дэмжлэг үзүүлэх зэрэг олон гоё заалт байгаа юм. Бүр оюутнуудыг ажлын байраар хангахын тулд "Хувийн хэвшлийн байгууллага (100 ба түүнээс дээш ажилтантай) нийт ажилтнуудын таван хувьтай тэнцэхүйц оюутны цагийн ажлын орон тоо гаргах" гэж албадан хуульчилсан. Гэвч эдгээр заалтын "амтыг мэдрэх" цаг өнгөрчихөөд байхад биелэлээ олсон нь хаа байна вэ. Хуулиар хариуцах эзэн, хэрэгжүүлэх байгууллагыг нь заагаад, хариуцлага тооцох механизмыг нь суулгаад өгчихсөн байхад биелүүлэхгүй байгаа нь дургүйд хүчгүйн үлгэрийг санагдуулж байна.

2017 онд хууль батлагдсанаар хуулийн хэрэгжилтийг хангах бүтцийг ч төрийн захиргааны төв байгууллагаас эхлээд аймаг, нийслэл, дүүрэгт бий болгосон. Хүн амынх нь гуравны нэг буюу 1.1 сая иргэний хөгжлийн асуудлыг хариуцсан бүтэц яагаад ажлаа хийхгүй байгаа тухай албаны хүнээс тодруулах нь учир шалтгааны тайлбар болох дог.

ЗГМ: ТОДРУУЛГА

Н.Мандуул: Гэр бүл болох залуус заавал сургалтад хамрагдана

Залуучуудын хөгжилд зориулж төрөөс ямар ажил хийж байгааг Нийслэлийн Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газар (ХГЗХГ)-ын дарга Н.Мандуулаас тодруулаа.

-Залуусын хөгжлийн бодлогын талаар нийгэм дэх ойлголт хангалтгүй, ямар байгууллага хариуцдагийг ч мэдэх хүн алга. Үүнд тайлбар өгөөч?

-Нэг зүйлийг иргэд ойлгох хэрэгтэй. Залуучуудын хөгжлийг хариуцсан бүтэц 2016 оноос өмнө огт байгаагүй нь үнэн. 2017 онд УИХ хуулийг нь батлахад би ажлын хэсэгт ажиллаж байсны хувьд бүтэц бий болгоход оролцсон. Өнөөдрийн байдлаар ХНХЯ, ХГЗХГ, аймаг, нийслэл, дүүргийн салбарууд хуулийн хэрэгжилтийг хангана. Мөн бид туршилтаар Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций суманд салбарын үйл ажиллагаа явуулж байгаа. Хүний хөгжил өндөр хөгжсөн орнуудад маш олон жил болсон ажлыг бид одоо л дөнгөж эхлүүлж байгаа учраас хүмүүст хүрээгүй байна.

-Монголын залуучуудын хөгжлийг хариуцсан байгууллага өнгөрсөн хугацаанд юу хийсэн юм бэ?

-Залуучуудад төрийн үйлчилгээг үзүүлэхийн тулд эрх зүйн орчныг бий болгох нь чухал. Бид эхний ээлжинд эрх зүйн орчныг бий болгож хэн юу хийхийг тодорхой болгосон. Хууль батлагдсанаас хойш залуучуудад чиглэсэн сургалт нөлөөллийн болон үйлчилгээ үзүүлэх ажил хийхээр төлөвлөсөн. Үйлчилгээ үзүүлэх хүрээнд 2019 оноос Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлэх нэр төрлийг тодорхой болгохоор ажиллаж байна.

-Ямар үйлчилгээнүүд байх юм бол?

-Тухайлбал, гэр бүлийн боловсрол олгох үйлчилгээг ирэх долдугаар сараас үзүүлж эхэлнэ. Түүгээр гэр бүл болох хосууд гэрлэлтээ батлуулахын өмнө заавал ХГЗХГ болон салбар нэгж дээр тав хоногийн сургалтад хамрагдах юм. Тэнд гэр бүлийн амьдралд тулгардаг бэрхшээлүүд, даван туулах арга зам, хүүхдээ хэрхэн асрах хамгаалах гэх зэрэг гэр бүлтэй холбогдсон олон мэдээллийг сургалтаар олгоно. Энэ нь нэг төрлийн үйлчилгээ. Мөн мэргэжлээ зөв сонгох үйлчилгээг тогтмолжуулахаар ажиллаж байна. Өнөөдөр сургууль төгсөх үеэр сайн дурын хүмүүс сургуульд очиж сурталчилгаа маягаар хийдэг байсан бол бид мэргэшсэн зөвлөгөө өгнө. Мөн өсвөр насныханд их тохиолдож байгаа сэтгэл гутралыг засахын тулд сэтгэлзүйн мэргэжлийн байгууллагатай хамтарч үйлчилгээ үзүүлнэ.

-Залуус өөрсдөд нь зориулсан төрийн бодлого гэж юу байдгийг мэдэхгүй байна. Та нар хууль таниулж, хийх ажлаа сурталчлах ёстой юм биш үү?

-Өнөөдөр хүн бүхэн интернэт, сошиал орчинд чөлөөтэй нэвтэрч байна. Гэтэл түүгээр дамжуулан нэг удаа ч болов төрөөс ямар бодлого хэрэгжүүлэх гэж байна гээд ороод үзчихгүй л байгаа юм. Бид энэ хандлагыг өөрчилнө. Бодлого хэрэгжүүлэх ажил дөнгөж эхэлж байна. Таван жилийн дараа манай залуусын хандлага огт өөр болно.

-Залуучуудын хөгжих, чөлөөт цагаа өнгөрөөх газар байхгүй байхад яаж хөгжих вэ?

-Тийм орчныг нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Ер нь хөгжлийн бодлого гэдэг та өөрөө хүс тэгвэл бид дэмжье гэсэн зарчим дээр л явах учиртай. [ЗГМ]

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

Нийслэлийн Авто замын хөгжлийн газар нь "Тусгай замын автобус" төслийн хүрээнд хийгдэх **Энхтайваны гүүрний баруун талаар гарах авто зам, төмөр зам доогуурх нүхэн гарц, Дунд гол дээгүүрх гүүрийн нарийвчилсан зураг төсөл" боловсруулах ажлыг** хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Мэдүүлгээ ирүүлж буй хуулийн этгээд (түншлэлийн гишүүн бүрт нэгэн адил хамаарна) нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж байгаагаа нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:

1. Тендерт оролцох сонирхлоо илэрхийлсэн болон уг хуулийн 14.1-д заасан нөхцөл үүсээгүйг мэдэгдсэн албан бичиг;

2. Аж ахуй нэгжийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн нотариатаар баталгаажуулсан хуулбар /Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 131 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан журмын:

2.8.1.4. Хотын авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах,

2.8.1.7. Гүүр, туннелийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байна

эсвэл

Зам тээврийн хөгжлийн сайдын 2012 оны 212 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан журмын:

2.3. хотын зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах,

4.1. Гүүр, туннелийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байна.

3. Байгууллагын танилцуулга;

4. Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт, Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн тодорхойлолт болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт;

5. Татварын болон Нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй болохыг тодорхойлсон тодорхойлолт;

6. Сүүлийн 3 жил /2016-2018/-ийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан;

7. Сүүлийн 3 жилийн ижил төстэй зөвлөх үйлчилгээ үзүүлсэн талаарх танилцуулга,

8. Хяналтын багт ажиллах голлох мэргэжилтнүүдийн танилцуулга, гүйцэтгэсэн ажлын туршлагын мэдээлэл, боловсролын зэргийн диплом, дипломын хавсралт

Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

Энэхүү зөвлөхийн тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул **(tender.gov.mn)** хаягаар орж дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.

Гадаадын этгээд оролцох эрхтэй бөгөөд гадаад этгээд оролцох бол дээрх шаардагдах баримт бичгийн 4,5 дугаар заалтыг шаардахгүй бөгөөд 9 дэх хэсгийн нийгмийн даатгалтай холбогдох баримт бичгийг бүрдүүлэх шаардлагагүй бөгөөд 2 дугаар заалтын тусгай зөвшөөрөлд тавигдах шаардлагад өөрийн орны дүйцэхүйц тусгай зөвшөөрлийг ирүүлнэ.

Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг **2019 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 18 цаг 00 минутаас өмнө** авч болох бөгөөд мэдүүлгээ дээр дурдсан хаягаар **2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 15 цаг 00 минутад** ирүүлнэ үү.

Монгол, Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг,
4-р хороо, Нийслэлийн нутгийн захиргааны
2-р байр Хангарди ордон,
Утас: 70111183 , Факс: 11-324498
Имэйл хаяг: Munkhod060313@gmail.com

НИЙГЭМ

Д.Цэвээнжав: Жолоочийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай

Г.Санжааханд
ЗГМ

Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт болон тулгамдаж буй асуудлын талаар Албан журмын даатгагчдын холбооны Гүйцэтгэх захирал Д.Цэвээнжавтай ярилцлаа.

-Жолоочийн даатгалын тухай хууль хэрэгжиж эхлээд найман жил болж байна. Хуулийн хэрэгжилт хэр байна вэ?

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 2012 онд эхэлсэн. Тухайн онд нийт 353 мянган хүн хамрагдаж байсан бол одоо 655,454 болж нэмэгдсэн байна. Харин төлсөн даатгалын хураамж нь 2012 онд 15 тэрбум 221 сая төгрөг байлаа. Гэтэл 2018 оны байдлаар 31 тэрбум төгрөг болж хоёр дахин нэмэгдсэн. Энэ тоо баримтыг харахаар хууль амжилттай хэрэгжиж байгаа дүр харагдана. Гэхдээ цаана нь даатгалд хамрагдаагүй 100 гаруй мянган тээврийн хэрэгсэл бүхий хувь хүн, хуулийн этгээд байгаа. Мөн уг хуулийн үр шимийг хүртэж чадаагүй гэсэн гомдолтой хүн ч бий. Үүнээс гадна хохирогч хохирлоо бүрэн төлүүлж чадаагүй гэсэн гомдол ч гардаг учраас яг юунаас болж асуудал үүсээд байна вэ гэдгийг бид сөхөж ярих хэрэгтэй.

Жолоочийн хариуцлагын даатгал нь тээврийн хэрэгсэл эзэмшигчид замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын өмнө хүлээх хариуцлагаа даатгуулах зорилготой гэдгийг хуульд заачихсан. Мөн бусдын эрх ашгийг хохироож, зам тээврийн осол гаргасан бол учруулсан хохирлыг даатгалын байгууллагаар төлүүлэхийн тулд даатгалын үнэлгээнд тохирсон хураамж төлж гэрээ байгуулж байгаа юм. Нийт даатгуулагчдын ердөө тав хүрэхгүй хувь нь жилд ямар нэгэн осол, зөрчил гаргаж, даатгалаас хохирол нөхүүлдэг бол үлдсэн 95 хувь нь нэг ч удаа бусдад хохирол учруулаагүй, нөхөн төлбөр гаргуулаагүй даатгуулагчид байдаг. Эдгээр хүмүүс яагаад даатгалаас урамшуулал, хөнгөлөлт авахгүй байна вэ гэсэн гомдол гаргадаг юм. Энэ бол яах аргагүй анхаарал татах асуудал байгаа. Аливаа даатгалын мөн чанар нь даатгуулж байгаа зорилго тодорхой, үр дүнг хэрхэн хүртэх нь ойлгомжтой байх явдал шүү дээ. Түүнээс хязгааргүй байнга л аваад, төлөөд байдаг юм гэж хаа байх вэ.

-Уг хуулийн хэрэгжилтэд тулгамдаж буй ямар асуудлууд байна вэ?

-Тулгамдаж буй хэд хэдэн асуудал байна. Нэгдүгээрт, Жолоочийн даатгалын тухай хууль батлагдаж, Даатгалын тухай хуульд жолоочийн даатгалын үйл ажиллагааг эрхлэх байгууллагын зохион байгуулалт, эрх үүргийг тодорхойлсон зүйл заалт нэмж оруулсан.

► 6

Нийгэм

Д.Цэвээнжав: Жолоочийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай

Даатгуулагчдын 95 хувь нь нэг ч удаа нөхөн төлбөр гаргуулаагүй байна

◀5

Манай байгууллагатай холбоотой энэ зүйл заалтыг аваад үзэхээр амьдралын хэрэгцээний дагуу зайлшгүй нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага бий болжээ. Тухайн үед хууль боловсруулж, батлуулж байсан хүмүүс албан журмын даатгалыг төдийлэн сайн ойлгоогүйгээс агуулгын хувьд тээврийн хэрэгслийн сайн дурын даатгалтай хольсон, уг хуулийг хэрэгжүүлэхдээ ч зохион байгуулалтын хувьд алдаа гаргасан байна.

Тиймээс хуульд яаралтай өөрчлөлт оруулах хэрэгтэй байна. Хоёрдугаарт, жолоочийн хариуцлагын даатгалаар жилд 30 гаруй тэрбум төгрөгийн хураамж төвлөрүүлж, түүний 53 хувийг зам тээврийн ослын улмаас хохирсон хүмүүсийн хохирлын нөхөн төлбөрт олгож байна. Энэ нь жилд 15-17 тэрбум төгрөг шүү дээ. Гэтэл үүнийг юуг үндэслэж олгоод байна вэ гэхээр даатгалын хохирол үнэлгээний тайлан буюу хэн нэгний бичсэн дүгнэлт, үнэлгээнд тулгуурлаж байгаа юм. Үнэлгээчид тээврийн хэрэгслийн эвдрэлийг үнэлж байна л даа. Гэхдээ тэдний баримтлах үнэлгээний аргачлал одоо болтол батлагдаагүй байх юм. Мөн зам тээврийн ослыг газар дээр нь баримтжуулдаг шуурхай албаны нэгдсэн журмыг Санхүүгийн зохицуулах хороо одоо болтол баталж өгөөгүй, арав гаруй даатгагчид өөрийн үзэмжээр баталсан журам мөрдөж байна. Хуульд зам тээврийн ослын дуудлагыг хүлээн авч, даатгалын үйлчилгээ хэрхэн явагдаж хохирогчид нөхөн төлбөр хэрхэн олгогдсоныг хянах боломжийг бий болгоогүй байх жишээтэй.

Ж.Гэрэлчулуун / ЗГМ©

Гуравдугаарт, албан журмын даатгал улсын хэмжээнд явагдаж байна. Гэтэл орон нутагт энэ даатгалд хамрагдвал зохих даатгуулагчийн гуравны нэг нь байгаа юм. Тэр хэсгийнх нь 30 орчим хувь даатгалд хамрагдаж чадаагүй, түүнийг хэн шаардаж хамруулах нь сайн дурын хэрэг болсон. Тэгэхээр орон нутагт даатгалын үйл ажиллагаа олон талаар доголдоод байна гэсэн үг. Орон нутагт арилжааны даатгалын компаниудын шуурхай алба, хохирол үнэлгээний компанийн салбар зэрэг дэд бүтцийг байгуулж ажиллуулахгүй байгаа нь даатгуулагчдыг ихээхэн чирэгдүүлж байна. Үүнээс болоод энэ даатгалын үйл ажиллагаа орон нутагт доголдож байна гэсэн үг. Ер нь жолоочийн хариуцлагын даатгалыг даатгалын компани, зуучлалын компаниуд мөнгө олох хэрэгсэл гэж ойлгоод байна. Нөгөө сайн дурын агуулгаар ойлгоод байгаа гэсэн үг. Уг нь хариуцлагын даатгал бол жинхэнэ даатгуулагчдадаа хандсан үйлчилгээ байх ёстой. Даатгуулагч, хохирогчийн эрхийг хамгаалах ёстой. Мөн бусдад хохирол учруулж, байнга нөхөн төлбөр гаргуулдаг даатгуулагчидтай тооцох хариуцлагыг ч өндөржүүлэх шаардлагатай байна. Гэтэл энэ ажлыг хэн хариуцаж хийх нь ойлгомжгүй байна.

Дөрөвдүгээрт, Даатгалын тухай хууль болон Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт тийм ч хангалттай биш. Хуулийн зарим заалт хэрэгжихгүй байхад хяналт тавьж байгаа байгууллага огт алга. Манай холбоонд хяналтын чиг үүрэг өгөгдөөгүй. Бид хуулиар даатгагчийнхаа үйл ажиллагаанд үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй. Гэтэл хуулиар даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах асуудал бүрэн орхигдсоныг буруугаар ашиглах хандлага газар авч байна. Энэ мэт тулгамдсан асуудлууд нь хуульд нэмэлт өөрчлөлт оруулахыг шаардаж байна. Ер нь хуулийн зарим зүйл заалт ойлгомжгүй, зарим даатгуулах ёстой субъект орхигдсон зэрэг нь асуудал үүсгэж байна.

-Жолоочийн даатгалын үйлчилгээг цахим болгож байгаа гэсэн. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?

-Манай Албан журмын даатгагчдын холбооны үндсэн чиг үүргийн нэг нь албан журмын даатгалын үйл ажиллагааны мэдээллийн сан ажиллуулах явдал. Энэ мэдээллийн сан их ач холбогдолтой үүрэг гүйцэтгэн, ажиллаж байна. 2018 оны байдлаар 650 мянган хувь хүн, хуулийн этгээд даатгуулж, түүний түүх, мэдээллийг хадгалж даатгагч нарт үйлчилж байна. Эдгээр мэдээллийн аюулгүй байдлыг хангахад ихээхэн анхаарал хандуулдаг. Үүнтэй холбогдуулан орчин үед нэвтрээд байгаа блокчейн технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр программ хангамжийг ашиглалтад орууллаа. Үүний зэрэгцээ 650 мянган даатгуулагч даатгалын компани эсвэл зуучлагч дээр очиж гэрээ хийх гэж бөөн ажил болдог хуучин аргыг өөрчилж, онлайнаар цахим гарын үсгээ ашиглан даатгалаа хийлгэх боломж нөхцөлийг бий болгоод байна. Энэ үйлчилгээг ашигласнаар даатгалын хүртээмжийг нэмэгдүүлж, даатгуулагчдад цаг, зардал хэмнэх боломж нээж өглөө. Тоон гарын үсгийн зөвшөөрөл авсан 12 мянган хүн байна. Цахим гарын үсэг ашиглаж жолоочийн даатгалын гэрээ хийх туршилтыг Дархан-Уул аймагт эхлүүлсэн. Ер нь ирэх сараас орон даяар бүрэн нэвтрүүлж эхэлнэ.

Мөн Албан журмын даатгагчдын холбоо “АЖД” аппликейшныг ашиглалтад оруулаад байна. Энэ аппликейшныг та өөрийн ухаалаг гар утсандаа татаж суулгаснаар даатгалын гэрээ болон даатгалын үйлчилгээний талаарх мэдээллийг бүрэн авч болно. Үүнээс гадна зам тээврийн осол гаргасан тохиолдолд дуудлага өгч, таван төрлийн зураг авч илгээхэд та замын цагдаа болон даатгагчийг хүлээх шаардлагагүй боллоо. Үүнийг хүлээж авдаг дуудлага үйлчилгээний нэгдсэн төвийг ч мөн байгууллаа. Албан журмын даатгагчдын холбоо зөвхөн даатгагч төдийгүй даатгуулагч танд ч даатгалын үйлчилгээг улам ойртуулсаар байна.

Даатгалаар жилд 30 гаруй тэрбум төгрөгийн хураамж төвлөрүүлдэг

-Жолоочийн даатгалын тухай хуульд зайлшгүй өөрчлөлт оруулах ямар асуудлууд байна. Түүнийг хэзээ, хэрхэн шийдвэрлэх вэ?

-Засгийн газрын хөтөлбөрт тусгагдсан ажил шүү дээ. Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын шийдвэрээр хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэг байгуулагдаад жил гаруй хугацаа өнгөрлөө. Юуны өмнө албан журмын даатгалын одоогийн зохион байгуулалтыг зах зээлийн зарчмаар өөрийгөө зохицуулах байгууллага эсвэл төрийн мэдэлд шилжүүлэх нь зохистой. Ер нь зөвхөн жолоочийн хариуцлагын даатгал биш тээврийн хэрэгсэл эзэмшигчийн хариуцлагын даатгал байх нь олон улсын жишигт нийцнэ. Даатгуулагчдын эрх ашиг хамгаалагдах ёстой. Зам тээврийн осол гаргаагүй боловч жил бүр хураамж төлдөг, осол гаргасан нь бусдад учруулсан хохирлоо бусдаар төлүүлчихээд санаа амар байх нь тийм ч зохистой бус байгаад даатгуулагчид шүүмжлэлтэй хандаж байна. Үүнийг авч үзэх ёстой.

Үүний зэрэгцээ жолоочийн хариуцлагын даатгал эрхлэх зөвшөөрлийг хэт хавтгайруулж олгосон нь хуулийн зорилгыг алдагдуулахад хүргэсэн. Энэ хуулийг батлуулахдаа тухайн үеийн СЗХ-ны дарга “Жолоочийн хариуцлагын даатгалыг орон нутагт салбар нэгжтэй цөөн даатгагчид хариуцуулна, үр ашиг нь даатгалын компанид биш даатгуулагч нарт зориулагдана” гэж хариулж байсныг та бүхэн санаж байгаа байх. Харамсалтай нь эсрэгээрээ болсныг дахин авч үзвэл зохино. Ямар ч байсан төрөөс энэ хуулийг даатгалын компанийн үүсгэн байгуулагч хүмүүсийн халаасыг зузаалах гэж батлаагүй байх. Иймучраас хууль хэрэгжүүлэх явцад бий болсон гажуудлыг яаралтай өөрчлөх хэрэгтэй. Хууль хэрэгжүүлэх нэрээр хууль бус үйл ажиллагаа явуулж байгаа ноцтой асуудал байгааг ч авч үзэх цаг болсон.

Даатгалын тохиолдлын улмаас хүний амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлыг эмнэлэг, эмч нарын дүгнэлтээр бодит зардалд, эд хөрөнгийн хохирлыг засварын газар, эсвэл оношилгооны байгууллагын үйл ажиллагаатай холбож хохирол тооцдог олон улсын жишгийг хэрэгжүүлэх нь зүйтэй. Жолоочийн хариуцлагын даатгалыг хэрэгжүүлж байгаа 166 орон бий. Тэгэхээр гарцаагүй хэрэгжүүлэх ёстой, нийгмийн ач холбогдол нь илүү чухал даатгал мөн гэдгийг баталж байна. Албан журмын даатгалын үйл ажиллагааг цахим болгох ёстой. Ингэснээр ил тод байдал, шударга ёс хангагдана. Хууль хэрэгжүүлэх ажлыг санаатай саатуулж, зохион байгуулалттайгаар эсэргүүцэж, хяналт шаардлагыг сулруулахыг эрмэлзэгчдэд боломж олгохгүй байхыг даатгуулагчдын эрх ашиг шаардаж байгааг онцлох нь зүйтэй. [ЗГМ]

ЭРҮҮЛ МЭНД

Ж.Амарсанаа: Сүрьеэгийн халдварыг маш сайн хянадаг бодлого алдагдсан

Салбарын сайд дорвитой арга хэмжээ авахгүй байсаар ноцтой байдалд хүргэлээ

Б.Сэлэнгэ
ЗГМ

Сургуулиудаас сүрьеэ илэрсэн тохиолдол бүрийг тоолж суухаас өөр дорвитой арга хэмжээ авахгүй байгаа Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэлийг огцор гэж эцэг эх, багш, ТББ-ын төлөөлөл жагсав. Нийгмийн гоц халдварт өвчин болох сүрьеэ гарсан даруйд нь арга хэмжээ авахын оронд харин ч бусад эцэг эхчүүдэд мэдэгдэхээс нууж, гал унтрааж явсаар өнөөдрийн ийм байдалд хүргэсэн гэж тэд салбарын сайдыг буруутгаж байна.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн 15 дугаар сургуулийн 529 сурагч, 97 дугаар сургуулийн 70 сурагчаас сүрьеэгийн халдвар илэрсэн талаарх мэдээ нийгмийг түгшээгээд буй. Тэгвэл Төв аймагт 200 сурагч сүрьеэ өвчний халдвар авсан нь мөн тогтоогдсон гэж жагсагчид хэлэв.

С.Батсайхан / ЗГМ©

“Тун удахгүй олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр тохиох гэж байна. Гэвч энэ өдөр хүүхдүүдэд баярлах шалтгаан гарахгүй нь. Сүрьеэ бол маш аюултай өвчин. Ийм олон хүүхэд халдвар авчихаад байхад ЭМЯ яагаад ажиллахгүй байна вэ. Сүрьеэгийн халдвар зөвхөн нэг хүүхдийн асуудал биш. Халдвар авсан хүүхдийн цаана гэр бүл, нэг ангид хамт суралцаж байгаа хүүхдүүдийн эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудал хөндөгдөнө. Бид тэмцлээ үргэлжүүлнэ. Хариуцлагагүй байдлын улмаас жирийн иргэд хохирох ёсгүй. Бусад эцэг, эхчүүдийг бидэнтэй нэгдэхийг уриалж байна” гэж жагсагчдын төлөөлөл бүхий эцэг эхчүүд хэлсэн юм. Харин “Хөгжлийн түлхүүр эмэгтэйчүүд” ТББ-ын тэргүүн Г.Хажидмаа “15 дугаар сургуулийн сурагчдад хүчээр эм уулгасныг багш нар нь ярьж байна. Сүрьеэгийн эм бол маш хүчтэй нөлөөтэй. Хүүхдүүдийн элэг, ходоодыг гэмтээдэг эм. Гэтэл яагаад эмчийн хяналтгүй, дур мэдэн хүчээр энэ эмийг уулгаж байгаа юм бэ. Хариуцлагыг нь хэн хүлээх вэ” хэмээв.

Хүний их эмч Д.Эрдэнэсувд 15 дугаар сургуульд хийсэн сүрьеэгийн тандалт судалгааны дүнгээр хамрагдсан нийт хүүхдийн 10 хувь нь сүрьеэгийн далд хэлбэрийн халдвартай нь илэрч байсныг хэлэв. Гэвч тухайн үед салбарын яамнаас арга хэмжээ аваагүйн уршиг өнөөдөр гарч байна гэдгийг тэрбээр тодотгосон юм. Д.Эрдэнэсувд “Хэрэв тухайн үед асуудлыг анхааралдаа авч, шуурхай ажилласан бол өнөөдөр энэ олон хүүхэд эрүүл мэнд, ирээдүйгээрээ хохирохгүй байлаа” гэсэн юм.

Жагсаалд оролцогчид удаа дараа алдаа гаргаж, мөрийн хөтөлбөрийнхөө хэрэгжилтийг хангаагүй Эрүүл мэндийн сайдыг огцрохыг шаардаж, ЭМЯ-нд шаардлага хүргүүлж байгаа аж. Сургуулиуд сүрьеэгийн голомт болоод байхад ЭМЯ дорвитой арга хэмжээ авахын оронд харин ч авлига, албан тушаалын хэрэг хийгээд сууж байгааг ч шүүмжиллээ. Тэд Эрүүл мэндийн сайдад өгсөн шаардлагынхаа хариуг хоёр хоногийн дараа авна хэмээн мэдэгдэж байв.

Энэ үеэр тус жагсаалд оролцогч, Эрүүл мэндийн дэд сайд асан Ж.Амарсанаагаас зарим зүйлийг тодрууллаа.

-Өнөөдрийн жагсаалын гол зорилго нь юу юм бэ. Сурагчдын дунд бий болоод буй сүрьеэгийн халдварын талаар эмч хүний хувьд ямар дүгнэлт өгч байна вэ?

-Эрүүл мэндийн яамны үйл ажиллагаа хангалтгүй, тус салбарын сайд салбараа удирдаж чадахгүй байна гэсэн үндэслэлээр бид тэмцэл хийж байна. Монгол Улс олон өвчлөлөөр дэлхийд тэргүүлж байна. Жишээлбэл, хорт хавдар. Элэгний хорт хавдрын нас баралтаар нэгдүгээрт, ходоодны хорт хавдрын нас баралтаар мөн нэгт, цус харвалтын гаралтай нас баралтаар хоёрдугаарт орж байна. Үүний хажуугаар сүрьеэгийн өвчлөл гараад ирлээ.

Сүрьеэгийн халдварыг уг нь маш сайн хянадаг байсан. Гэтэл өнөөдөр тэр бүх бодлого алдагдаж, өмнө нь гаргасан амжилтаасаа ухраад эхэллээ. Зөвхөн нэг сургуульд 500 гаруй хүүхэд сүрьеэгийн халдвартай нь тогтоогдож, олон хүүхэд идэвхтэй сүрьеэгийн халдвартай гарсан. Идэвхтэй сүрьеэгийн цаана халдвар маш идэвхтэй явагдаж, бусдад халдвар дамжуулах магадлалтай байдаг. Тэгэхээр сургуулийн орчинд хүүхэд сурч боловсрох бус, өвчин авах орчин бүрджээ гэж харж байгаа.

-Та өмнө нь тус яамны дэд сайдаар ажиллаж байсан. Таныг байхад сүрьеэгийн өвчлөл өнөөдрийнхтэй харьцуулахад ямар байсан бэ?

-Намайг ажиллаж байхад тандалт, судалгаа хийгдээгүй байсан. Тандалт судалгаа хийх ажлыг эхлүүлж, түүний үр дүн 2016 онд гарсан. Тухайлбал, сургуулийн насны хүүхдүүдийн 10 хувь нь далд сүрьеэтэй болох нь тогтоогдсон. Харамсалтай нь, тэр дүнг Д.Сарангэрэл сайдад дуулгасан боловч арга хэмжээ авахгүй байсаар өнөөдрийн ийм ноцтой нөхцөл байдал үүссэн гэж харж байна. Тиймээс салбарын сайд хариуцлага хүлээх ёстой. [ЗГМ]

ZGM DAILY

Miners start the year with revenue increase

Mining companies paid a total of MNT 2.1 trillion to the state budget.

IPO financing will be spent on refinancing loan sources

The mid-term goal of the company will focus on Central Asia.

TRQ share prices fall after OT Investigation results

Turquoise Hill Resources share prices fell 3.5 percent to CAD 1.66 at the TSE.

Top 20 index drops 0.29 percent, to 20,036.97 points

Market cap stands at MNT 2.36 trillion.

ZGM: HIGHLIGHTS

POLITICS

At the Cabinet meeting, a program on integrating patriotism, Mongolian culture and civilization into all levels of high school textbooks has been approved.

ECONOMY

Top 20 index drops 0.29 percent, to 20,036.97 points. MSE A index decreases 0.1 percent to, 9,255.55 points. MSE B index declines 3.6 percent, to 7,506.55 points. Market cap stands at MNT 2.36 trillion.

SOCIETY

An international conference themed Sustainability in the Cashmere Supply Chain was organized by the Sustainable Fiber Alliance NGO.

Pegas Touristik, one of the largest tourism network commences its first branch in Mongolia.

Batsaikhan.S / ZGM©

Miners start the year with revenue growth

Oyu Tolgoi spent USD 296.4 million on underground development in the first quarter

Aminaa.U
ZGM

Mining projects that have a major impact on Mongolia's economy saw splendid expansion in the first quarter. The Top 100 Mongolian firms included Erdenet Mining Corporation (EMC), Erdenes Tavan Tolgoi (ETT) and Oyu Tolgoi (OT). These companies paid a total of MNT 2.1 trillion to the state budget last year.

COPPER

Oyu Tolgoi, one of the main mining projects in Mongolia, spent USD 296.4 million on underground development in the first quarter of this year. The second shaft is still ongoing and it is expected to end in October.

Xanadu Mines, listed on the Australian Stock Exchange announced the result of additional exploration at Kharmagtai deposit.

In the first quarter of this year, the capital balance of the company reached AUD 3.1 million, while post-tax losses nearly halved from the same period last year. The share price of the company reached AUD 0.08 at the Australian Stock Exchange.

GOLD

Erdene Resource Development Corp. (ERD), Toronto Stock Exchange (TSX) and the Mongolian Stock Exchange (MSE) listed firm, has conducted drilling at the Khundii field and expanded the mineralization of the Bayan Khundii deposit. The company explained its plans in a report to support the feasibility study of the project. "The exploration of the project on the Midfield area found 5.9 grams of gold per tonne at a depth of 112 meters per. This affirms the high mineralization in the main part of the Bayan Khundii deposit," said the CEO of the company Peter Akerley. The share prices of ERD at the TSX reached CAD 0.19.

COAL

SouthGobi Resources, operating at Ovoot Tolgoi mines increased its coal sales by over 80 percent to 1.1 million tons in the first quarter of the year. The average selling price of the company has decreased from USD 43 in 2018 to USD 34.9. The net profits have doubled from the previous year to USD 13.4 by reducing the cost. [ZGM]

COMMODITY MARKET

Brent Crude (ICE)
(USD/bbl.)



Bloomberg©

Copper (Comex)
(USD/lb.)



Bloomberg©

Gold (Comex)
(USD/t oz.)



Bloomberg©

WTI Crude Oil (Nymex)
(USD/bbl.)



Bloomberg©

LETTER OF INVITATION

Consulting Service for the Detailed Engineering Design of bypass to the West of the Enkhtaivan Bridge, Railway underpass, and Bridge over Dund River under the Project named Bus Rapid Transit (BRT).

The Road Development Department of the Capital City would like to invite all interested consultants to submit their Expression of Interest for Consulting Services for the Detailed Engineering Design of Road located on the West Side of the Enkhtaivan Bridge, Tunnel, and Bridge over Dund River under the Project named Bus Rapid Transit (BRT).

According to the Article 14-16 of the Procurement Law of Mongolia all interested consultants should submit the required materials as follows:

1. Written statement of submission of expression and declaration that the situation as given in Article 14.1 of Procurement Law of Mongolia has not arisen
2. Copies of state registration certificate and special permission /in accordance with Annexure to Decree No.131 of Road and Transportation Development Minister dated 2018/
   2.8.1.4 Designing urban road and road construction
   2.8.1.7 A license for designing a bridge or tunnel
   Or
   2.3 Design of urban roads and roads
   4.1 A License for design of bridge and tunnel
   /in accordance with Annexure to Decree No.212 of Road and Transportation Development Minister dated 2018/
3. Company profile
4. Statements issued by the Specialized court archive, Administrative court and by the Court Decision Enforcement Agency,
5. Statements issued by Tax and Social insurance departments
6. Audited financial statements for the last 3 years /2016, 2017, 2018/
7. Similar work experience for the last three years /2016, 2017, 2018/
8. CVs of key experts, information of previous work experience, copies of university diplomas, certificates, supervision engineer's certificate

To improve their capabilities, the Consultants can engage with other interested consultants as a Joint Venture.

This expression of interest is being advertised through e-procurement system and detailed information may be obtained from www.tender.gov.mn.

Foreign consultants are eligible to participate and not required to submit 4th, 5th items and the social insurance requirement of 9th item of the abovementioned requirements. Equivalent special permissions from its home country should also be submitted.

Interested consultants can obtain additional information before 18.00 hours of May 31, 2019 and the Expression of Interest must be delivered to the address of e-procurement system prior to 15:00 hours on June 05, 2019.

The Road Development Department of the Capital City,
5th floor, Capital governing office building No.2, Hangardi Tower
4th sub district, Chingeltei district, Ulaanbaatar, Mongolia
Phone number:70111183 Fax:11-324498
E-mail: Munkhod060313@gmail.com

ZGM: INTERVIEW

Ankhbold Bayanmunkh: IPO financing will be spent on refinancing loan sources

Namuun.A
ZGM

Official Gazette had the chance to speak with Ankhbold Bayanmunkh, CEO of InvesCore NBFI to clarify on the company's activity, vision, and plans.

-InvesCore NBFI is planning to launch an IPO in the secondary market. Would you please provide us some information on it?

-Our company is launching an IPO at the MSE tier-III with the purpose of raising MNT 17.6-18.7 billion from the public. It is the biggest amount of IPO issued by a private entity in the history of Mongolia's stock market. We are suggesting 85 percent of our stake to strategic investors and 15 percent to the public. The shares were cheaper to the strategic investors before. Our difference is that we are recommending our stock at a cheaper price to the public. In addition, it is the first time that many foreign investors are entering the Mongolian Stock Exchange (MSE) compared to previous years. Most of the strategic investors are foreigners.

-How is the company planning to spend the raised capital?

-We have planned to spend 100 percent of the funds to refinance our loan source. The advantage of the financial institution is that it can benefit from the raised money immediately. For example, factories only give dividends to investors after making profits from products sales.

-InvesCore NBFI is a company that is based on fintech. What are the advantages of this type of companies?

-About our company, we focus on business, cars, apartment, and commercial loans other than fintech products. We have observed that fintech-based products as the second big market for us. Also, one of our advantages is that we do not adopt technology from other companies. Subsidiaries of our company develop the products and own their intellectual property.

-Can you give details to some of your fintech products?

-We will commence our crowdfunding platform named "Crowd Fund" in June. As a public investment activity, there is a need for a comprehensive service such as audits, assessments, legal controls, financial controls, and guarantees besides the technological platform. We will also include a micro-credit app and an electronic wallet in the third quarter of this year.

-Your company is aiming to expand to Central and East Asian countries, is that right?

-We have been conducting market research on foreign markets since 2018 and a lot of opportunities have been observed so far. Most of the foreign investors are interested in East Asia. However, the big markets demand competitiveness. Our advantage is not enough out there. The mid-term goal of our company will focus on Central Asia. It has 70 million people which is 25 times bigger than our country's economy. It is a market big enough for Mongolians.

-Is Mongolian workforce ready to operate in abroad?

-One of the advantages of Mongolian youth is that they learn and adapt quickly. They have the potential to learn the other country's business specialty. We prepared our people since we already planned to expand our activity to the foreign market. [ZGM]

MINING

TRQ share prices fall after Parliament discloses OT Investigation results

Turquoise Hill Resources (TRQ) share prices fell 3.5 percent to CAD 1.66 at the Toronto Stock Exchange (TSE) after the Parliamentary Working Group reported on the investigation of Oyu Tolgoi (OT) LLC. Rio Tinto, ASX-listed mining firm, climbed 0.4 percent to AUD 101.7 per share.

The second largest taxpayer in the 2018 OT has invested more than USD 9 billion in Mongolia since the start of the project. The company has paid USD 322 million to the state budget in 2018. The subject of the Baker Mckenzie law firm's investigation on Rio Tinto is the construction of the OT underground development, according to the financial review.

The law firm is investigating how Rio Tinto is exploring the underground mine's geology and surface structure and its impact on the project's cost and time. It is related to small shareholders of Turquoise Hill Resources. [ZGM]

Өдрийн өнгө

ТВ ХӨТӨЛБӨР

MNB

- **07:00** "Өглөө" хөтөлбөр
- **09:05** Боловсрол: "Нейро шинжлэх ухаан ба бага насны боловсрол"
- **14:00** "Робокон-2019"
- **15:20** "Хүрээлэн" амьд ертөнцийн цуврал
- **18:30** Олон нийтийн цаг /шууд/
- **20:00** "Цагийн хүрд" мэдээллийн хөтөлбөр /шууд/

Bloomberg TV Mongolia

- **07:00** "Сая долларын суутан" нэвтрүүлэг
- **11:00** "#Made in Mongolia" баримтат цуврал нэвтрүүлэг
- **14:30** Байршил нэвтрүүлэг
- **17:00** Bloomberg Technology
- **20:00** Блумбергийн ярилцах цаг нэвтрүүлэг
- **21:00** "Мөнгөний урсгал" мэдээний хөтөлбөр

БОЛОВСРОЛ HD

- **08:00** "4 өнгө" цаг агаарын хөтөлбөр
- **11:10** "Хөгжилтэй монголдой" цэцэрлэгийн ахлах бүлэг №20
- **13:05** "Хөгжилтэй монголдой" 1-р ангийн хичээл №24
- **18:07** "Консуни" хүүхэлдэйн кино 27-28-р анги
- **19:00** "Бүхнийг анагаагч хайр" ОАК 2-р анги
- **23:00** "Хувь тавилангийн зэдрээ" ОАК 5-р анги

МОНГОЛ TV

- **07:00** Өнөө өглөө
- **11:40** "Пэппа торой" хүүхэлдэйн кино /season-1/ 11-13-р анги
- **13:30** "Ан амьтдын ертөнцөөр" /season-10/ 14-р хэсэг
- **16.00** "Миний найзууд" ОАК 13-р анги
- **17:30** "Мөрдөгч хүүхдүүд" /season-1/ 33-34-р анги
- **19:00** Оргил цаг мэдээллийн хөтөлбөр

"The HU-GEREG live Performance" концерт
Хаана: White Rock Center
Хэзээ: 2019.05.24 ний 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮99,999

"Сэтгэлийн километр" концерт
Хаана: Embassy restaurant-Бишрэлт Плаза зочид буудал
Хэзээ: 2019.05.24-ний 18.30 цагт
Тасалбарын үнэ: ₮ 30-50 мянга

Ж.Верди "Аида" дуурь
Хаана: УДБЭТ
Хэзээ: 2019.05.25-ны 17.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 10-30 мянга

ОНЦЛОХ ҮЗВЭР

Хүүхдэдээ баяраар нь өв уламжлалаа таниулаарай

УГЗ, Төрийн соёрхолт Ш.Бирваа болон Төрийн соёрхолт Б.Мөнхболдын хөгжим, Төрийн соёрхолт С.Сүхбаатарын дэглэлт, Х.Батаагийн зохиол хүүхдэд зориулсан "Ишиг хөөрхөн нэр" дуулалт жүжиг УДЭТ-т зургадугаар сарын 1-нд ганцхан удаа тоглох гэж байна. Үндэсний урлагийн их театрын бүжгийн чуулга энэхүү бүжгэн жүжгийг 2010 онд анх тайзнаа тавьж байжээ.

Нүүдэлчин монголчуудын ахуй амьдрал, ёс заншилдаа нийцүүлэн хүүхдийг өв тэгш хүмүүжүүлж, байгаль дэлхий, ан амьтнаа хайрлан хамгаалах ухааныг балчир насанаас нь сэтгэл зүрхэнд нь суулгадаг уламжлалыг өртөөлөхөд энэхүү жүжгийн ач холбогдол оршино. Өнөө цагт мал сүргийг ойроос ч харж үзээгүй хотын хүүхэд багачуудад уламжлалт аж ахуй, соёлын тухай ойлголт өгөх зорилгоор уг жүжгийг сэргээн тоглох шаардлагатай болсон юм. Эх үрсийн баяраар элдэв чихэр амттан, хийсвэр орчинд шүтсэн сонголтоо та эргэн харж, хүүхдүүддээ монгол ахуйг таниулах "Ишиг хөөрхөн нэр" дуулалт жүжгийг сонирхуулаад үзээрэй. [ЗГМ]



Ф.Херольд "Дэгүй Лиз" балет
Хаана: УДБЭТ
Хэзээ: 2019.05.26-ны 17.00 цагт
Тасалбарын үнэ: ₮10-20 мянга

Ц.Балдорж "Хайрын виз" уянгын драм
Хаана: УДЭТ
Хэзээ: 2019.05.28-30ны 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 10-20 мянга

"Маамуугийн төрсөн өдөр"
Хаана: White Rock Center
Хэзээ: 2019.05.31-ний 11.00, 14.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 15 мянга

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

	V.24	V.25	V.26	V.27	V.29
Өдөр	13°	10°	15°	24°	24°
Шөнө	9°	2°	0°	4°	9°
Салхи	12 м/с / 10 м/с	11 м/с / 9 м/с	7 м/с / 6 м/с	9 м/с / 6 м/с	9 м/с / 6 м/с
	Бороотой	Үүлшинэ	Багавтар үүлтэй	Багавтар үүлтэй	Үүлшинэ



ЗГМ: СҮДОКУ

9	8		3	6				
			1	7	2			9
	2			9		7	5	
8	9		7	4	3			6
5	1							
						4		2
			8				6	
	3	6				8		4
				1		9		7

(Өмнөх дугаарын хариу)

8	7	5	2	4	3	9	1	6
3	9	4	8	1	6	7	2	5
6	2	1	5	9	7	8	4	3
2	5	6	4	8	1	3	9	7
1	4	9	3	7	5	6	8	2
7	3	8	9	6	2	1	5	4
9	6	3	1	5	4	2	7	8
5	1	2	7	3	8	4	6	9
4	8	7	6	2	9	5	3	1

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



БОСООГООР:
1. Шүлгийн нэг мөр
2. Их хааны таалллаар нэрийг нь сольсон, Чингисийн 9-н өрлөгийн нэг жанжин
3. Уулзах тохиол
4. Ногоон өнгөтэй эрдэнийн чулуу
6. Олимпын 4 удаагийн аварга Японы алдарт бөх
8. Гариг...
10. Хар тамхи, саван зэргийн найрлагад ордог цэцэг
11. Чингис хааны элч болон 450 худалдаачныг алснаар өөрсдийн болон бусад улс орныг сүйрэлд дуудсан Хорезмын хот
13. Алдартай дарс
19. Үүрэн телефоны сүлжээ (товчилсон нэр)

ХӨНДЛӨНГӨӨР:
1. Шартай гүргэр
5. Өвөрхангай аймгийн ХДТеатр түүний нэрэмжит болсон МУГЖ агсан
7. "Тунгалаг тамир" романы баян Итгэлтийн хоч
9. Он, сар, өдрийн тэмдэглэгээ
12. Төрийн шагналт зохиолч, академич агсан
14. Сармагчин лугаа моддын хооронд дүүлдэг халуун орны урт сүүлт амьтан
15. Дотор махны нэгэн хэсэг өөх
17. Манай жуулчид, худалдаачид ихээр очдог Хятадын хот

Өмнөх дугаарын хариу / 05.23

З	У	С	Л	А	Н	■	А	Х	И	М	А	Г
У	■	А	■	Г	■	А	■	А	■	И	■	Е
Д	А	Н	З	А	Н	В	А	А	Н	Ч	И	Г
■	С	■	О	■	О	■	Т	■	В	■	Г	■
Т	О	Г	О	Р	У	У	Н	Ц	У	В	А	А
О	■	А	■	И	■	М	■	А	■	О	■	Т
П	А	Р	О	Д	И	■	М	А	Г	Н	А	Г

ЗУРХАЙ



Билгийн тооллын 21
Зуны тэргүүн шарагчин могой сарын нэг цагаан мэнгэтэй цагаагчин тахиа өдөр
Үс засуулбал: Өвчин ирнэ
Наран ургах, шингэх: 05.05-20.33 цаг
Барилдлага: Шид
Шүтэн барилдлага: Өтлөх үхэхүй
Суудал: Уул

Аргын тооллын тавдугаар сарын 24. Сугар гараг. Билгийн тооллын 21, Гоё хүүхэн одтой, цагаагчин тахиа өдөр.
Өдрийн наран 05.05 цагт мандан, 20.33 цагт жаргана. Тухайн өдөр үхэр, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлд шамдах, бүтээл туурвил эхлэх, худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, зэрэг дэвших, угаал үйлдэх, хагалгаа хийлгэх, гэр бүрэхэд сайн. Мод суулгах, нарийн зөвлөгөөн хийхэд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

"МИАТ" ТӨХК борлуулагч агентлагууддаа талархлаа

"МИАТ" ТӨХК Монгол Улсад нислэгийн тийз борлуулагч агентуудтай өнгөрсөн оны хамтын ажиллагаагаа дүгнэж, амжилттай ажилласан агентуудад өргөмжлөл гардуулж, талархал илэрхийллээ. 2018 оны "Шилдгийн шилдэг борлуулагч агент"-аар "Аэрмаркет" ХХК, "Шилдэг борлуулагч агент"-аар "Эйртранс", "Эйрлинк" Монголиа компани шалгарав. Мөн амжилттай ажилласан "Эйртикет", "Эйр ЭкспертТрейвэл", "Мон-Аэртур", "Эйр Экспресс Трэвел" компанид батламж гардууллаа.

"МИАТ" ТӨХК "Аялал жуулчлал-Агаарын тээвэр" сэдвийн дор аялал жуулчлалынхантай зөвлөлдөх уулзалт зохион байгуулж ирэх жилийн төлөвлөгөөгөө танилцуулсан бол энэ удаа тийз борлуулагч агентуудтай хамтын ажиллагаагаа ийнхүү дүгнэсэн байна.

Дашрамд дурдахад "МИАТ" компани энэ онд Азийн чиглэлд нислэгийн сүлжээ, давтамжаа нэмэгдүүлж БНХАУ-ын Гуанжоу, 7-8 дугаар сард Осака руу, мөн Москва болон Берлин рүү шууд нислэг үйлдэх юм байна.

Европтой танилцах боломж

Mongolia - European Union
DIPLOMATIC RELATIONS

Монгол Улс болон Европын Холбоо дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх "Европын нээлттэй өдөрлөг"-ийг анх удаа энэ сарын 26-ны өдрийн ням гарагт Сүхбаатарын талбайд зохион байгуулах гэж байна.

Тус өдөрлөгийн үеэр Европын Холбооны гишүүн орнуудын соёл уламжлалтай танилцах, үндэсний хоол, амттанаар дайлуулж, урлагийн тоглолт үзэх боломжийг иргэдэд олгох юм. Мөн Европын Холбооны санхүүжилтээр Монгол Улсад хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд, аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа танилцуулах ба гишүүн улсууд руу аялах боломж, шенгений виз хэрхэн авах талаар дэлгэрэнгүй зөвлөгөө, мэдээлэл өгөх аж. Энэ талаар Европын Холбооноос Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Траян Лауренцю Христеа "Өдөрлөгт ирсэн иргэд Европын Холбооны татвар төлөгчдийн мөнгийг яагаад Монгол Улсад хэрэгжүүлж буй төслүүдэд зарцуулж байгаа талаар илүү сайн ойлголт авах боломжтой. Бид энэхүү өдөрлөгөөр европ болон монгол хүмүүсийн харилцааг илүү ойртуулна гэж найдаж байна" хэмээлээ.

Б.Батлхагва: Сэргээгдэх эрчим хүчний нөөц хоёр дахин нэмэгдсэн

Төслийн хөрөнгө оруулалт хэдэн зуун тэрбум ам.доллараар яригдана.

>11

Манай экспорт Хятадын ганцхан өдрийн хэрэгцээг ч хангахгүй

Хятадын махны далай шиг зах зээлийн дэргэд Монголын нийлүүлэлт дусал мэт аж.

>12

Хятадын баячууд тансаг завь худалдан авдаггүй

Блейк Шмидт

Тансаг том завь зарах янз бүрийн арга мэх байдаг авч Хонконгийн брокер Эрик Нойелд энэ бүхэн үр дүнд хүрдэггүй гэнэ. Хятадуудын хувьд шүү дээ. Мэдээж хамгийн томоос нь эхэлж санал болгоно. Энэ нь яг худалдах гэж буй завь биш ч байж болно. Оны эхээр ноён Нойел өөрийн хамтран эзэмшдэг 79 тохой урт завийг маркетингдаа ашиглав. Зузаан хэтэвчтэй цөөн хүн урьсны дотор завьтай болович илүү томыг хайж байгаа гэх Хятадын нэг баян байжээ.

Нойелын Asia Marine Yacht Service компани хийлч хөлслөн тоглуулж, намуухан эгшиг дунд долоон хоолтой зоог барьсан аж. Гэвч тэр үдэш нэг ч хэлцэл хийлгүй дууссан байна. Хятадаас даруухан хэмжээтэй тансаг завь худалдан авагчийг олоход бэрх гэж тэрбээр ярилаа.

Дэлхийн 200 том завь эзэмшигчийн дотор гуравхан хятад хүн байдаг гэж Boat International Media компанийн судалгаанд дурджээ. Хятад улс сүүлийн арван жилд аль ч улсаас олон тэрбумтнуудыг төрүүлсэн агаад тэд Оросын олигархууд, Цахиурын хөндийн старт-апыг үндэслэгч шиг мөнгөө юунд зарахаа мэднэ. Хувийн урлагийн бүтээлийн цуглуулга, спортын баг, гольфын талбай худалдан авдаг болович завь л биш. Хятадууд завиар юу хийхээ мэддэггүй байх хэмээн Ноён Нойел хошигножээ. Тэрбээр "Азид маш цөөн хүн завийг зөв ашиглаж, дэлхий даяар бие даан аялах боломжийг мэддэг" хэмээн өгүүлэв. 79 тохой буюу 24 метр урттай, мэргэжлийн баг ажиллуулдаг завийг супер завь гэсэн ангилалд оруулдаг. Жишээ нь Oracle компанийн захирал Ларри Эллисон 288 тохой урт завин дээрээ сагсны талбайтай. Британийн хөрөнгө оруулагч Жо Льюс 321 тохой урт завиндаа Фрэнсис Бэконы 70 сая ам.долларын үнэтэй гурамсан зураг байрлуулжээ.

Үнэ нь хэдэн сая доллараас 400 сая ч хүрдэг. Арваад жилийн өмнө Хятадын баячууд тэрбумтнуудын завины флотод нэгдэх байх гэсэн хүлээлт үүссэн. 2012 онд China Cruise & Yacht холбоо 2020 он гэхэд Хятадад 100 мянган тансаг завь бий болно хэмээн таамаглаж байв. Тухайн үед янз бүрийн хэмжээний 3000 орчим ийм ангилалд багтаж болохуйц завь байсан аж. Саниа хотод завины шоу зохион байгуулдаг China Rendez-Vouz компанийн захирал Делфин Лигниер "Тэд одоогийнхоос илүү тансаг бараа худалдан авч, гольф тоглодог байсан. Дэлхийгээр аялж, нүд тайлахыг хүсдэг байв. Гэвч авлигын эсрэг арга хэмжээ тансаг завины мөрөөдлийг дарсан байх" хэмээн тайлбарлав.

Завины худалдаачид 2012 онд Шин Жиньпин Коммунист намын удирдлагыг гартаа авна гэдгийг таамаглаагүй байх. Тэрбээр авлига, тансаг хэрэглээнд дайн зарласан юм. Зуун мянга гаруй намын гишүүнд сахилгын хариуцлага хүлээлгэж, дээд албан тушаалтнуудыг тансаг буудал, үнэтэй зоогоос татгалзахыг шаардсан. Иймээс супер завь мэтийн чамин тоглоом авахыг хүсэгчдийн хувьд тааруухан цаг үе иржээ. Завины шоунд очсон хүмүүс хэрхэн зохисгүй тансаглаж байгааг харуулсан нийгмийн сүлжээний бичлэгийг төрийн хэвлэлүүдэд гаргаж, шүүмжилсэн байна.

Жишээ нь, Коммунист намын төв хэвлэлийн Англи хэл дээрх хувилбар Global Times сонинд "Хятадын 200 сая иргэн ядуу амьдарч байхад ингэж баян тансгаа гайхуулах нь гэмт хэрэг" хэмээн бичжээ. Heysea Yachts group компанийн захирал Фан Юан "Хэрэв тэд АНУ-д байшин, үнэт эдлэл аван бол хэн ч мэдэхгүй. Гэтэл тансаг завь худалдан авбал нууж чадахгүй. Усан дээр зогсох том завийг яалтай билээ" хэмээн өгүүлсэн байна. 2015 оноос Хятад улс завин дээрх хүний тоог үйлчилгээний багийг оролцуулаад 12-оос дээшгүй байх ёстой гэж заасан. Ийм тооны хязгаар дотор тансаг аялал, үдэшлэг хийнэ гэдэг бүтэшгүй зүйл юм.

Авто үйлдвэрлэгчдийн халсан ажилчдын тоо 38 мянгад хүрлээ

Честер Доусон

Арван жил өсөлттэй байсан дэлхийн машины борлуулалт буурах хандлагатай болсон тул авто үйлдвэрлэгчид цалингийн зардлаа танах арга хэмжээ авч байна. Хятадаас эхлээд Британи, Герман, Канад, АНУ-ын компаниуд сүүлийн зургаан сард ажлын байраа 38 мянгаар цомхотгожээ. Энэ бол дөнгөж эхлэл гэж зарим шинжээч үзэж буй. Daimler-ын захирал Дитер Зетче лхагва гарагт хэлсэн үгэндээ тус салбарт урьд үзэгдээгүй эргэлт гарч, зардлыг огцом танах болно хэмээн анхааруулав.

Түүнчлэн Merrill Lynch-ийн шинжээч Жон Мэрфи "Авто үйлдвэрлэгчид нэлээд бууралт ирнэ гэдгийг ойлгож байгаа бололтой" гээд Хятадын өсөлт гайхал төрүүлэх хэмжээгээр саарах байх хэмээн таамаглажээ. Дэлхийн томоохон компаниуд үйлдвэрээ шилжүүлэхээ зогсоож, зарим газарт хааж байгаа болович хэмнэлтийн бодлого үүнээс ч цааш явж магадгүй байна. Дэлхийн хоёр том зах зээл АНУ, Хятадад машины борлуулалт буурахын сацуу автын гол үйлдвэрлэгчид цахилгаан ба өөрийн жолоодлоготой автомашин үйлдвэрлэх ирээдүйд бэлтгэж эхэлжээ.

Долоо хоногийн эхээр Ford дэлхий даяар цагаан захтай ажилтнуудынхаа 10 хувь буюу 7000 хүнийг халахаа зарласан. Энэхүү бууралт АНУ-ын өндөр тарифын улмаас бүр ч хүнд тусаж болзошгүй. Дотоод, гадаадын авто үйлдвэрлэгчид худалдааны улмаас Америкт 700 мянган ажлын байр эрсдэлд орж магадгүйг анхааруулжээ. Toyota болон Японы автын салбарынхан Трампын тарифын бодлогыг нэлээд хатуу үгээр шүүмжилсэн. Morgan Stanley-н шинжээч Адам Жонас "Дэлхий даяар үйлдвэрлэл унаж болзошгүй цаг үед машины компаниуд хэрхэхээ бодож тунгааж байна" хэмээн дүгнэв. Тэрбээр цалин, орлогын харьцааг үнэлээд Ford-ын цомхотгол үүгээр зогсохгүй, орлого нь таван хувиар агшсан тул нэмж 23 мянган цалинтай ажилтнуудаа халах шаардлагатай болно хэмээн тооцжээ.

Дэлхийн хэмжээнд 2018 онд машины борлуулалт 0.5 хувиар буурч, 94.8 сая болсон. Энэ нь 2009 оноос хойш анх удаа жилийн үзүүлэлтээр буурч байгаа хэрэг юм гэж LMC Automative фирм дүгнэсэн байна. Morgan Stanley-н нэгдүгээр сард гаргасан таамгаар энэ онд машины борлуулалт дахиад 0.3 хувь буурах төлөвтэй байгаа. Борлуулалтад Хятадын зах зээл гол сөрөг нөлөө үзүүлнэ гэж тус банкны эдийн засагчид дүгнэсэн байна. Гэвч Daimler-ыг олон жил толгойлсон ноён Зетче Берлинд хэлсэн үгэндээ "Бүх зүйл хяналтад байгаа" гэсэн юм.

ХЯТАДЫН HIKVISION ХЭНИЙ Ч ЗУРГИЙГ АВСАН БАЙЖ БОЛЗОШГҮЙ

Жереми Кан

АНУ-ын засаг захиргаа Хятадын дүрс бичлэгийн хяналтын хоёр том компанид хориг тавих асуудлыг хэлэлцэж байна. Гэвч тэдний камерууд Америкийн хотуудын гудамж болон цэргийн баазуудад хэдийн суурилагджээ. Hikvision, Dahau компаниуд олонд танигдаагүй болович тэдний хяналтын камерууд таны зургийг авсан байх магадлал өндөр. Энэ хоёр компани дэлхийн видео хяналтын зах зээлийн гуравны нэгийг эзэлдэг гэж Deutsche банкны мэдээнд дурджээ. Эдний камеруудыг АНУ-ын оффис, нисэх буудал, сургууль, Засгийн газрын байруудад суурилуулсан төдийгүй дэлхий даяар түгээмэл ашигладаг аж.

ЭНЭТХЭГИЙН SUN PHARMACEUTICAL КОМПАНИ ЭМ БҮТЭЭНЭ

Ари Алстедтер

Сүүлийн дөрвөн жилд үнэлгээнийхээ 65 хувийг алдсан Sun Pharmaceutical компани зах зээлд дахин үсрэлт хийхээр бэлтгэж байна. Энэтхэгт эм үйлдвэрлэлээр тэргүүлэгч тус компани эм хуулбарлахаас хавьгүй ашигтай өөрийн патенттай эм боловсруулахад ихээхэн хөрөнгө хаяжээ. Эмийн салбарын дэлхийн аварга компаниудаас судалгаа, хөгжүүлэлтийн ажилд зарцуулсан хөрөнгө нь нөхөгдөх эсэх нь тодорхойгүй байгаа үед ийм зорилт тавих нь нэлээд эрсдэлтэй. Sun-гийн захирал Дилип Сангхви инновацад тулгуурлан шинэ эм бүтээхийн тулд чадвартай мэргэжилтнүүдийн багийг бүрдүүлж эхэлсэн байна. Тэрээр "Энгийн эм үйлдвэрлэхээс арай илүү авьяастан олох хэрэгтэй. Гэхдээ боломжгүй зүйл биш" хэмээн ярьжээ.

PRADA БРЭНД ЗАГВАРТАА АМЬТНЫ АРЬС АШИГЛАХГҮЙ

Роберт Уильям

Загварын ертөнцийн домогт зохион бүтээгчдийн нэг Миүччи Прада арьс, үсээр хийсэн бүтээгдэхүүн гаргахаа мэдэгджээ. Миланд төвтэй Prada компанийн уран сайхны удирдагч хийгээд гол хувьцаа эзэмшигч тэрбээр ирэх есдүгээр сард болох загварын шоунаас эхлэн арьс, үсээр хийсэн хувцас, чимэглэл гаргахгүй хэмээн амлав. Амьтан хамгаалагчид хэдэн арван жил тэмцсэний үр дүнд урьд Burberry, Gucci зэрэг загварын орднууд ийм шийдвэр гаргасан юм. Хэрэглэгчид загварын нийгэм, байгаль орчны үр нөлөөнд ихээхэн анхаардаг болж буй өнөө цагт брэндүүд ёс суртахууны үүргээ ухамсарлаж, амьтны арьснаас татгалзаж буйгаа харуулахыг эрмэлзэж байгаа юм.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдөр

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт зохион байгуулах сургалтын байгууллагыг сонгон шалгаруулах
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: НХЭГ/ХЭХ-2019/07

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар нь эрх бүхий тендерт оролцогчоос **"Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт зохион байгуулах сургалтын байгууллагыг сонгон шалгаруулах"** НХЭГ/ХЭХ-2019/07 дугаартай зөвлөхийн бус үйлчилгээ үзүүлэх тухай үнийн санал бүхий цахим тендер ирүүлэхийг урьж байна.
Тендерийн материалыг төрийн худалдан авах ажиллагааны систем **www.tender.gov.mn** хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж **50,000 төгрөгийг** www.tender.gov.mn цахим хуудасны дагуу банкны мерчантийн системийг ашиглан төлнө.
Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.
Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ.

Үүнд: **Багцгүй.**

Тендерийг **2019 оны 07 дугаар сарын 05–ны өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаар нэвтэрч ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 10 цаг 30 минутад** Нийслэлийн үйлчилгээний Дүнжингарав салбарт байрлах "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв"-д нээнэ.

Гадаадын этгээд тендер **ирүүлэх эрхгүй.**
Дотоодын давуу **эрх тооцохгүй.**

Баганууp, Багахангай, Налайх дүүрэгт зохион байгуулах боломжтой бол хүсэлт ирүүлэх.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Г.Амарын гудамж,
соёлын төв өргөө "Г" корпус 5 давхарт, Нийслэлийн Хөдөлмөр Эрхлэлтийн газар, 515 тоот өрөө,
Утас: 70110502, 70130502

Төв банкны мэдээлэл

НЭЭЛТТЭЙ ЗАХИДАЛ

Ардчилсан намаас Монголбанкны үйл ажиллагаа, банк санхүүгийн салбарын үзүүлэлтүүдтэй холбоотой буруу ташаа, илт гуйвуулсан мэдэгдэл гаргажээ. Иймд банк, санхүүгийн үзүүлэлтүүдтэй холбогдох бодит мэдээллийг энэхүү нээлттэй захидалаар хүргэж байна.

Монголбанк улс орны эдийн засгийг сэргээх, улсын өрийн дефолтын эрсдэлээс зайлсхийх, эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах, дархлааг сэргээх, банк санхүүгийн салбарыг эрүүл, чийрэг болгоход чиглэсэн бодлого, арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлж, үр дүнд хүрч ирлээ. Эдгээрээс тус намын мэдэгдэлтэй холбоотой дараах 5 бодит баримтыг энд товч дурдъя.

Нэг. Инфляц зорилтот түвшний орчим тогтвортой байж, төгрөгийн ам.доллартай харьцах ханш эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэй тогтож ирлээ.

Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд мөнгөний бодлогын үндсэн зорилтыг хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг 2017-2019 онд жилийн 8 хувь орчимд тогтворжуулах хэмээн баталж, үүний дагуу Монголбанкны бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж ирэв. Монголбанк нийт эдийн засагт чиглэсэн мөнгөний бодлогыг хэрэгжүүлдэг тул улсын инфляцыг зорилтот түвшиндээ байлгахыг зорьж ажилладаг. Монголбанк сүүлийн 3 жилд инфляцын зорилтыг бүрэн биелүүлж ирлээ (Зураг 1).

Зураг 1. Жилийн инфляц (улс)

Зураг 2. УБ хотын жилийн инфляц



Эх сурвалж: Монголбанк

Инфляц 2016 оноос хойш алгуур өссөн нь эдийн засгийн сэргэлтээр тайлбарлагдана. Хэт бага инфляц, дефляци нь эдийн засгийн уналт, идэвхигүй байдлыг илэрхийлдэг бөгөөд эдийн засгийн хүндрэлтэй холбоотойгоор 2016 онд инфляц 1.6 хувьтай байв. Инфляц нь тодорхой зэрэг түвшинд байснаар үйлдвэрлэгч, үйлчилгээ үзүүлэгч нар үйлдвэрлэл, бизнесээ өргөжүүлэх боломж, сэдэлтэй бий болгож байдаг. Энэ утгаараа инфляцыг зорилтот түвшний орчим тогтвортой байлгах нь эдийн засгийн тогтвортой байдал, өсөлтөд эерэгээр нөлөөлдөг. Сүүлийн 2 жил гаруй хугацаанд эдийн засагт сэргэлт гарч, 2019 оны эхний улирлын байдлаар өсөлт 8.6 хувьтай гарч, ажилгүйдлийн түвшин буурч, инфляц зорилтот түвшний орчим тогтвортой байна. Үүнд төсөв, мөнгөний бодлогын цаг тухай бүрт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ чухал үүрэг гүйцэтгэж ирэв.

Инфляц 2019 оны 4 дүгээр сарын эцсийн байдлаар улсын хэмжээнд 7.0 хувь, Улаанбаатар хотод 7.8 хувьтай буюу зорилтот түвшинд хадгалагдаж байна. Улаанбаатар хотын жилийн инфляц зөвхөн 2018 оны 12 дугаар сард 9.7 хувьд хүрч урьдчилан төсөөлсөний дагуу эргэн буурaад байна. Энэхүү инфляцын 5.4 нэгж хувь нь шатахуун, хатуу түлш болон махны үнийн өсөлт буюу нийлүүлэлтийн шинж чанартай үнийн өсөлт голлон тайлбарлаж байна (Зураг 2). Мөнгөний бодлогоор нийлүүлэлтийн шалтгаантай түр зуурын инфляцад хариу арга хэмжээ авах нь ажил эрхлэлт, үйлдвэрлэл буурахад сөргөөр нөлөөтэй. Монголбанкны төсөөлэлтэй нийцтэйгээр Улаанбаатар хотын инфляц эргэн буурч, одоо зорилтот түвшний орчим байна.

2016 оны 7 дугаар сараас 2019 оны 5 дугаар сарын хооронд төгрөгийн ам.доллартай харьцах ханш 30 хувиар суларсаны 23 нэгж хувийн сулралт нь 2016 оны сүүлийн 5 сард бий болжээ. 2016 оны сүүлийн хагаст төгрөгийн ханш хүчтэй сулрахад өмнөх бодлогын үр дагавар, тухайн үеийн эдийн засгийн хүндрэл гол нөлөө үзүүлэв (Зураг 3). Тухайлбал, 2016 оны эхний 3 улиралд дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) өмнөх оны мөн үеэс -1.6 хувийн уналттай, -0.6 хувийн дефляцитай, ажилгүйдлийн түвшин 11.6 хувьд хүрсэн, улсын төсөв өндөр алдагдалтай (1.7 их наяд төгрөг), зээлийн өсөлт зогсонги байдалд орсон, банкны салбарын чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлийн 15.4 хувьд хүрсэн, зээлийн хүү өсч 20.6 хувьд хүрч өсөн, гадаад валютын цэвэр нөөц Монголбанкны тодорхойлолтоор -402.5 сая ам.доллар, ОУВС-гийн тодорхойлолтоор -2.75 тэрбум ам.долларт хүрээд байв. Энэ нөхцөл байдал 2015 оноос хойш үргэлжилж, банк санхүүгийн байгууллагуудын алдагдал нэмэгдэж, өөрийн хөрөнгө буураад байсан буюу эдийн засгийн хүндрэл нь санхүүгийн салбарт шилжээд байв.

Зураг 3. Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн савлагаа (стандарт хазайлт)



Эх сурвалж: Монголбанк

2016 оны 7 дугаар сард гадаад валютын албан нөөц 1.2 тэрбум ам.доллар, ХАБ-тай байгуулсан төгрөг, юаны своп хэлцлийн хүрээнд Монголбанк авч ашигласан дүн 1.6 тэрбум ам.доллар, харин дотоодын банкудтай хийсэн своп хэлцлийн цэвэр дүн 1.4 тэрбум ам.доллар байж, гадаад валютын цэвэр нөөц -2.75 тэрбум ам.долларт хүрсэн байв. Гадаад валютын нөөц ийнхүү буурч, цэвэр дүнгээр сөрөг өндөр түвшинд хүрсэн, 2016 оны 6 дугаар сарын 28-нд их хэмжээ (400 орчим сая ам.доллар)-ний гадаад валют дотоод зах зээлээс гарсан, төсвийн болон төлбөрийн тэнцлийн олон жилийн алдагдал гүнзгийрсэн, нөгөө талдаа өндөр дүнтэй гадаад өр төлбөрүүд (Хөгжлийн банкны 580 сая ам.доллар, ХАБ-тай байгуулсан хэлцлээр авч ашигласан 12 тэрбум юань, Чингис бондын 500 сая ам.доллар, Димсам бондын 1 тэрбум юань) хүлээгдэж байсан нь валютын захад оролцогчдын хүлээлтэд нөлөөлж, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш 2016 оны сүүлийн 4 сард сулрахад нөлөөлөв. Гадаад валютын нөөц ийнхүү бага түвшинд хүрч, макро эдийн засгийн гол үзүүлэлтүүд бүгд эдийн засгийн хүндрэлийн нөхцөл байдлыг илтгэж байсан тул Монгол Улсын зээлжих зэрэглэл 2016 оны 7 дугаар сараас мөн оны 11 дүгээр сарын хооронд маш хурдацтай буурсан юм. Тухайлбал, Moody's агентлаг зээлжих зэрэглэлийг 2 шатлалаар бууруулж Caa1 ангилалд оруулсан билээ. Ийнхүү зээлжих зэрэглэл буурсан нь Улсын эрсдэлийг өсгөж, гадаад зах зээл дээр гаргасан бондуудын үнэ хурдтай унаж, хүү (Хөгжлийн банкны бондын үнэ унаж, хоёрдагч зах зээл дээрх хүү нь 38 хувьд хүрсэн) нь өсч байв.

Эдийн засгийн суурь үзүүлэлтүүд суларсан орчинд төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн сулрах дарамт өндөр байсны дээр 2016 оны сүүлийн 4 сард төгрөгийн дараах валюттай харьцах ханш сулрахад дараах хүчин зүйлс нэмэлт дарамтыг бий болгов. Нэгд, Засгийн газар, хөгжлийн банкны санхүүжилт болон Монголбанкны төсвийн шинж чанартай арга хэмжээний хүрээнд эдийн засаг дах төгрөгийн нийлүүлэлт их хэмжээгээр нэмэгдээд байв. Хоёрт, 2016 оны эхний хагаст Засгийн газраас хэрэгжүүлсэн "Сайн" хөтөлбөрүүдийг Монголбанкнаас санхүүжүүлээд байв. Энэ нь мөн эдийн засаг дахь төгрөгийн нийлүүлэлтийг нэмэгдүүлж, төгрөгийн ханш сулрах урьдач нөхцөлийг бүрдүүлсэн байв. Гурав, 2016 оны 6 дугаар сарын сүүлээр Эрдэнэт үйлдвэрийн 49 хувьтай холбоотойгоор дотоодын банкнаас их хэмжээний валют (нийт гадаад валютын нөөцийн 30 хувьтай тэнцэх хэмжээний) гадаад төлбөрт шилжүүлсэн нь сүүлд тодорхой болов. Өөрөөр хэлбэл, төгрөгийн их хэмжээний нийлүүлэлт хийгдсэн үед дотоодын банкнаас том дүнтэй валют бөөн дүнгээр гадагшилсан нь гадаад валютын хомсдолыг бий болгож, төгрөгийн ханш богино хугацаанд хүчтэй сулрахад нөлөөлсөн анхны суурь том шалтгаан байв.

Зах зээлд оролцогч иргэд, аж ахуйн нэгжүүд улс төр, нийгэм, эдийн засагт үүсч буй нөхцөл байдлыг ажиглах, нээлттэй байгаа статистик мэдээллийг олж авах, түүнд дүн шинжилгээ хийх чадвартай билээ. Нөгөө талдаа, төв банк өөрийн гаргадаг статистик мэдээллийг нийтэд үнэн бодитоор цаг тухайд нь хүргэх үүрэгтэй. Бодит нөхцөл байдал, статистик мэдээлэл нийтэд ил болох үед гадаад валют худалдан авахын төлөөх түр зуурын "сандрал" бий болсны дээр банкууд зарах валютын хэмжээндээ хязгаарлалт тогтоож байв. Гадаад валютын өндөр дүнтэй цэвэр гадагшлах урсгалтай, валютын нөөц нь 1 тэрбум байгаа нөхцөл байдалд Монголбанк валютын захад үргэлжлүүлэн идэвхтэй интервенци хийх боломжийг хязгаарлагдаад байв. Валютын тодорхой томоохон дүнтэй орох урсгал тодорхой болоогүй үед төв банкнаас том дүнтэй интервенци хийж, гадаад валютын бага хэмжээний нөөцийг үргэлжлүүлэн бууруулах тохиолдолд ханшийн хямралд хөтлөх үр дагавартай байв.

Гэхдээ Монголбанкнаас долларжилтын идэвхжилийг бууруулах, төгрөгийн ханшийн сулрах дарамтыг багасгахад шаардлагатай арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэв. Тухайлбал, 2016 оны 8 дугаар сард бодлогын хүүг 4.5 нэгж хувиар нэмэгдүүлэн 15 хувьд хүргэх шийдвэр гаргав. Энэхүү арга хэмжээ нь тодорхой хугацаанд үр дүнгээ өгч төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн сулрах дарамтыг бууруулж, зах зээлд оролцогчдын итгэлийг сэргээх, валютын томоохон орох урсгалыг бий болгох хугацааг олгосон юм. Төгрөгийн үнэ цэнийг хамгаалах тус арга хэмжээ нь үндсэний мөнгөн тэмдэгт богино хугацаанд хүчтэй суларч, урт хугацааны тэнцвэрт түвшнээсээ хэт хазайх үед төв банкнаас хэрэгжүүлдэг стандарт арга хэмжээ билээ.

Сүүлийн 2 жил гаруй хугацаанд гадаад болон дотоод эдийн засгийн суурь хүчин зүйлс төгрөгийн ханшийг сулруулах дарамттай үед Монголбанкнаас ханшийг тогтмол барих нь гадаад валютын нөөцийг бууруулж, УИХ-аас баталсан Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл, Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр (ӨСХ)-ийн хүрээнд Монголбанкны хүлээсэн үүргийг зөрчихөөр байв. Тухайлбал, ӨСХ-ийн хүрээнд хүлээсэн нэг амлалт нь Монголбанкны гадаад цэвэр актив буюу валютын цэвэр албан нөөцийг тохиролцсон дүнгээр шат дараатай нэмэгдүүлэх явдал юм. Урсгал тэнцлийн өндөр алдагдалтай орчинд энэхүү үүргийг биелүүлэх явдал түйлын хүнд байсан тул валютын зах дээрх оролцоог зарим үед хязгаарлах нөхцөл байдал ч үүсч байв. Хөтөлбөрийн хүрээнд хүлээсэн энэхүү тоон зорилтыг бүрэн биелүүлэхгүй тохиолдолд Монгол Улс хөтөлбөрөөс гарахад хүрэх ноцтой үр дагавартай тул Монголбанк энэхүү тоон зоринтод хүрэх, ханшийн тогтвортой байдлыг хангах гэсэн хүнд сорилтыг нэгэн зэрэг хангах шаардлагатай тулгарч байв. Өөрөөр хэлбэл, нэг талдаа эдийн засгийн дархлааг хангах, эмзэг байдлыг бууруулах, нөгөө талдаа ханшийн хэт өндөр хэлбэлзлийг бий болгохгүй байх энэ зорилтыг амжилттай хэрэгжүүлэхэд Монголбанкны бодлого чиглэж ирлээ.

Олон улсын санхүүгийн байгууллагуудын өмнө хүлээсэн үүргээ амжилттай хэрэгжүүлэх хүрээнд Монголбанк гадаад валютын албан нөөц (ГВАН)-ийн хэмжээг нэмэгдүүлэх бодлогыг баримталж ирсэний үр дүнд ГВАН 3.8 тэрбум ам.долларт хүрээд байна.

Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр (ӨСХ) хэрэгжиж эхэлсэн 2017 онд төгрөгийн ханш оны турш тогтвортой байв. Харин төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2018 онд 8.9 хувиар суларсан нь импорт, гадаад өр төлбөр болон гадаад зах зээлд гарсан томоохон өөрчлөлтүүдтэй холбоотойгоор валютын захад илүүдэл эрэлт байж, сулрах хүлээлт давамгайлж, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн сулрах дарамт өндөр байсны үр дагавар юм. Тухайлбал, 2018 онд валютын ханшид нөлөөтэй дараах гол өөрчлөлтүүд гарав:

АНУ-ын Холбооны Нөөцийн Банк 2018 онд бодлогын хүүгээ нийт 4 удаа, өсгөж 2.50%-д хүргэв. Ингэснээр гадаад зах зээлээс санхүүжилт бүрдүүлэх өртөг нэмэгдэж, төлбөрийн тэнцлийн санхүүгийн дансаар дамжин Монгол Улсад орох валютын урсгал хязгаарлагдмал болов.

Монгол Улсын эдийн засаг сэргэж буйтай холбоотойгоор 2018 оны эхний 12 сарын байдлаар зээл олголт өмнөх оны мөн үеэс 24%, импортын хэмжээ 5.9 тэрбум ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 36%-иар өссөн нь валютын эрэлтийг нэмэгдүүлэх шалтгаан болов.

Экспортын орлого 13%-иар өсч, цэвэр дүнгээр гадаад валютын эрэлт, нийлүүлэлтээсээ хурдтай өсөв. Түүнчлэн нүүрсний экспортын 50 орчим хувийг бүрдүүлдэг Гашуунсухайт боомтын үйл ажиллагаа 2018 он дуустал доголдсоноос шалтгаалан экспортын орлого тасалдаж, нүүрсний экспорт Монголбанкны төсөөллөөс 250 сая ам.доллараар бага гүйцэтгэлтэй гарлаа.

Мөн ӨСХ-ийн хүрээнд 2018 олгохоор тохирсон гадаад санхүүжилтийн гүйцэтгэл 400 сая ам.доллараар бага байв.

Хоёр. Монголбанк сүүлийн 2 жилд төгрөгийн гадаад валюттай харьцах ханшид огцом хэлбэлзэл үүсгэхгүй байхад чиглэсэн бодлогын үр дүнтэй арга хэмжээнүүдийг хослуулан хэрэгжүүлж байна.

Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханшид огцом хэлбэлзэл үүсгэхгүй байх хүрээнд 2018 онд гадаад валютын дуудлага худалдаагаар нийт 1.2 тэрбум ам.долларыг валютын захад нийлүүлэв. Дотоодын валютын зах зээл дээрх төв банкны оролцоо нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханшид огцом хэлбэлзэл бий болгохгүй байхад чиглэсэн буюу зах дээр эрэлт, нийлүүлэлтийн богино хугацааны зөрүүг нөхөх зорилготой байв. Өөрөөр хэлбэл, төв банкны оролцоог энэ хэмжээнээс хязгаарласан тохиолдолд төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн сулрах дарамт илүү өндөр байхаар байв.

Гадаад валютын эрэлт, нийлүүлэлтийн хэмжээ болон хугацаа харилцан адилгүй байдаг манай орны хувьд валютын эрэлтийг тогтвортой хангах, эрэлт, нийлүүлэлтийн түр зуурын шинжтэй зөрүү гаргахгүй байх үүднээс экспортлогч томоохон аж ахуйн нэгжүүдээс гадаад валютыг худалдан авч, уг валютыг захад ханшийн огцом хэлбэлзэл үүсгэхгүйгээр нийлүүлэх туршлагыг нэвтрүүлэв. Үүний зэрэгцээ 2018 оны 9, 11 дүгээр сард хуралдсан Мөнгөний бодлогын хорооны хуралаар гадаад валютын эрэлтийг бууруулах, төгрөгийн харьцангуй өгөөжийг нэмэгдүүлэх замаар төгрөгийн ханшийн хэлбэлзлийг бууруулах шийдвэрүүдийг гаргав. Тухайлбал бодлогын хүүг 1 нэгж хувиар нэмэгдүүлж, гадаад валютын эрэлтийг нэмэгдүүлдэг хэрэглээний зээлийн өсөлтийг хязгаарлах зорилгоор хэрэглээний зээлийн хугацааг 30 сараар хязгаарлах, хэрэглээний зээлийн өр орлогын харьцааг 70 хувиас хэтрүүлэхгүй байх, ханшийн эрсдэлтэй валютын зээлийн эрсдэлийн жинг 30 пунктээр нэмэгдүүлж 150 хувьд хүргэх макро зохистой бодлогын арга хэмжээг авав. Түүнчлэн 28 долоо хоногтой ТБҮЦ-ыг шинээр гаргахаар шийдвэрлэсэн нь төгрөгийн харьцангуй өгөөжийг нэмэгдүүлж, зах зээл дэх илүүдэл төгрөгийн эх үүсвэрийг урт хугацаагаар татах замаар валютын эрэлтийг бууруулж, улмаар эрчимтэй суларч байсан төгрөгийн ханшийн сулрах дарамтыг бууруулав.

Гадаад, дотоод хүчин зүйлсийн нөлөөгөөр 2018 онд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах дарамт харьцангуй өндөр байсан хэдий ч Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн бодлогын нөлөөгөөр бусад орнуудтай харьцуулахад төгрөгийн ханшийн сулралт харьцангуй бага байв. Тодруулбал 2018 онд төгрөгийн ам.доллартай харьцах ханш өмнөх оноос 8.9 хувиар, голлох 22 улсын валютын сагстай харьцах төгрөгийн ханш оны эхний 12 сарын байдлаар 2.8%-иар суларсан байна. Гэхдээ 8.9 хувийн сулралт нь түүхий эд экспортлогч бусад орнуудтай харьцуулахад харьцангуй бага үзүүлэлт бөгөөд Монголбанк ханшийн тогтвортой байдлыг хангахад анхаарч ажилласаныг илтгэнэ. Тухайлбал, ОХУ-ын рубль 21 хувиар, Казахстаны тэнгэ 14.4 хувиар, Австралийн доллар 10.8 хувиар суларчээ (Зураг 4).

Зураг 4. Голлох валютуудын эсрэг ам.долларын ханшийн өөрчлөлт



Эх сурвалж: Bloomberg

Дэлхий дахинд ам.долларын ханш чангарч буй нөхцөлд Монголбанкнаас төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг хүчээр тогтоон барих нь Монгол Улсын гадаад худалдааны өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж, гадаад худалдааны ашгийг бууруулж, улмаар төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг огцом сулруулах эрсдэлтэй.

Монголбанк 2019 оны эхний 4 сарын байдлаар валютын дуудлага худалдаагаар 804 сая ам.доллар нийлүүлээд байгаа бөгөөд төгрөгийн ам.доллартай харьцах ханш он гарснаас хойш тогтвортой байна.

Үргэлжлэл бий...

Эдийн засаг

Б.Батлхагва: Сэргээгдэх эрчим хүчний нөөц хоёр дахин нэмэгдсэн

Төслийн хөрөнгө оруулалт хэдэн зуун тэрбум ам.доллараар яригдана

Э.Батцэцэг
ЗГМ

Монгол Улс эрчим хүчний Азийн супер сүлжээнд нэгдэх төсөлд манлайлан оролцож буй. Нар, салхины цахилгаан станц байгуулахад хамгийн таатай газар манай улсын нутаг дэвсгэрт бий. Тодруулбал, улсын хэмжээнд үйлдвэрлэдэг нийт эрчим хүчнээс тав дахин их хүчин чадалтай сэргээгдэх эрчим хүчний станц говийн бүсэд байгуулах боломжтой ажээ. Азийн супер сүлжээ барьж байгуулах ТЭЗҮ-ийг нарийвчлан гаргаж буй олон улсын шинжээчдийн багт ажилласан "МонХорус Интернэшнл" компанийн тэргүүн дэд захирал Б.Батлхагваас сэргээгдэх эрчим хүчний тулгамдсан асуудлуудын талаар байр суурийг нь сонирхлоо.

Ж.Гэрэлчулуун / ЗГМ©

-Азийн супер сүлжээ байгуулахаар судалсан ажлын хэсэг дүгнэлтээ удахгүй танилцуулах юм байна. Онцлох мэдээлэл нь юу вэ?

-Азийн супер сүлжээ гэх концепц гарч ирснээс хойш нэлээд яриа өрнөж, сүүлийн хоёр жилийн хугацаанд Азийн хөгжлийн банкнаас ТЭЗҮ боловсруулах ажлыг санхүүжүүлсэн. Судалгааны үр дүнд энэ төсөл хэрэгжих боломжтой гэдгийг техникийн хувьд тогтоож, эдийн засгийн хувьд ч хөрөнгө оруулагчдын сонирхол өндөр байгааг мэдэгдсэн. Төслийн судалгааны явцад Монголын нар, салхины эх үүсвэрээс эрчим хүч гаргаж авах нөөц бололцоо илүү өндөр гарсан. 2001 онд салхины нөөцийг гаргахдаа тухайн үеийн хамгийн өндөр чадалтай буюу 500 МВт-ын турбин дээр тогтоож байсан юм. Харин энэ удаад том чадлын турбиныг зуу гаруй метрийн өндөрт байршуулж судалснаар салхины эрчим хүчний үзүүлэлт огцом нэмэгдлээ. Мөн нарны эрчим хүчний эх үүсвэрийг судлахад ч технологийн ашигт ажиллагааны үр дүнд нөөц өссөн. Товчхондоо говийн бүсийг нар салхины арвин их нөөцтэй газар нутаг гэдгийг судалж тодорхойллоо.

-Ирэх сард болох томоохон цугларалтын талаар тодруулъя?

-Зургадугаар сард болох UB dialogue хэлэлцүүлгийн гол сэдэв нь эрчим хүч байх юм. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга бүс нутгийн төрийн тэргүүнүүд Азийн супер сүлжээг барьж байгуулахад нэгдэх санамж бичигт гарын үсэг зурах санаачилгыг гаргасан. БНХАУ, БНСУ, ОХУ, Япон, Монгол зэрэг улсын тэргүүнүүд дэмжиж байж энэ төсөл бүрэн утгаараа хэрэгжих юм. Ирэх есдүгээр сар гэхэд ядаж хоёр орных нь тэргүүн гарын үсэг зурах байх гэж найдаж байна. UB dialogue хэлэлцүүлэгт оролцогч орнуудын ажлын хэсэг хуралдаж, санамж бичгийн нөхцөлийг тохирох юм. Мөн АХБ-аас хийсэн судалгааны дүнг эцэслэн танилцуулна.

-Нар, салхины эрчим хүчний нөөцийг хэдэн хувиар илүү гэж шинэчлэн тогтоосон бэ?

-Дүнг танилцуулаагүй учраас тодорхой тоо хэлэх боломжгүй байна. Ойролцоогоор нөөц хоёр дахин нэмэгдсэн. Монгол орон даяар судлахад шүү дээ. Харин нар, салхины эрчим хүч гаргаж авах хамгийн боломжтой бүс болох говийн нутгаар энэ тоо маш өндөр гарсан.

-Энэ нь эдийн засагт ямар өгөөж өгөх вэ?

-Эдийн засгийн хувьд асар их дэвшил авчирна л даа. Тухайлбал таван гегаватт чадалтай /Монголын эрчим хүчний системийг тав дахин ихэсгэсэн/ станц байгуулахад нэгжийн тариф нь 2.2 центээр зарагдах боломжтой.

Эрчим хүчний нэгжийн үнэ 2.2 центээр зарагдах боломжтой

Одоо байгаа тарифын хамгийн бага нь 5-7 цент. Тэгэхээр хамаагүй хямд эрчим хүч авч хэрэглэх боломжтой гэсэн үг. Энэ төсөлд Монгол Улс оролцож чадвал хөрөнгө оруулалтын хэмжээ тэрбум, тэрбум ам.доллараар яригдана. Үүнийг дагаад татварын орлого огцом нэмэгдэнэ. Тиймээс монголчууд Азийн супер сүлжээний төсөлд идэвх санаачилгатай, тэргүүлэх эгнээнд оролцож явах хэрэгтэй юм.

-Хэдий хэрийн санхүүжилт шаардлагатай вэ. Хөрөнгө оруулагчид хэр сонирхож байна?

-Хэдэн зуун тэрбум ам.долларын асуудал яригдаж байгаа тул дэлхийн бүхий л томоохон хөрөнгө оруулагчид, бүх сан үүнийг сонирхож байна. Танайх төслөө урагшлуул, бид оролцоход бэлэн гэсэн байр суурия илэрхийлсэн. Хамгийн гол нь түүнийг хэрэгжүүлэх байгууллага олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, чадвартай аппарат байх ёстой. Энэ ажилд улсаа төлөөлөх компанийн асуудлаар Монголын бизнесийн зөвлөлийн захирал Б.Бямбасайхан яриа хэлцэл хийж байна.

-Азийн супер сүлжээ байгуулж дуусах хугацааг хэдийгээр төсөөлж байгаа вэ?

-Ойрын 5-10 жилд бүрэн хэрэгжих боломжтой.

-2030 он гэхэд сэргээгдэх эрчим хүчний хувийг 30-д хүргэнэ гэж Тогтвортой хөгжлийн зорилтдоо тодорхойлсон. Бодит байдал ямар байна?

-Суурилагдсан хүчин чадлаараа 18 орчим хувьтай явж байгаа. Гэхдээ хэрэглээ талаасаа яривал таван хувьтай л явна. Иймээс үйлдвэрлэлээр нь тооцвол зөв дүн гарна.

-Суурилагдсан хүчин чадлаар нь хэрэглээг түгээхэд ямар бэрхшээл байдаг вэ?

-Монгол бол жижигхэн зах зээлтэй, техникийн хувьд сул орон. Хүлээж авах хүчин чадал нь бага байна. Эрчим хүчний систем тогтворгүй, бусад төрлийн эх үүсвэрээс авах хэрэглээг зохицуулж чадахгүй байна. Түүнчлэн үнийн асуудал хүндрэл учруулдаг. Өнөөдөр нэг квт эрчим хүчийг 122 төгрөгөөр үнэлж байна. Энэ бол цахилгаан үйлдвэрлэх, түгээх зардлаа ч нөхөж чадахгүй үнэ. Монголд аравхан мегаваттын цахилгаан станцууд хүртэл бий. Тэд бага эрчим хүчийг өндөр үнээр үйлдвэрлэж түгээгээд иим тарифаар борлуулах боломжгүй учраас сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ тэлэхэд хүндрэлтэй байна. Мөн нар, салхигүй үед эрчим хүч нөөцлөх төхөөрөмж маш өндөр үнэтэй учраас нэмэлтээр тавих боломжгүй. Энэ мэт шалтгаанаас сэргээгдэх эрчим хүчний нэгдсэн бодлого зайлшгүй хэрэгтэй болж байна. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» ТӨМӨР ЗАМ

27.7

Км. Газрын тос боловсруулах үйлдвэрийн 27.7 км төмөр замын ажлыг барьж дуусгажээ. Төмөр замчид, инженерийн багийн 110 гаруй хүн, тусгай тоноглолтой 122 вагонтайгоор бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэжээ.

» ЭКСПОРТ

17.3

Сая ам.доллар. Оны эхний дөрвөн сарын байдлаар 17.3 сая ам.долларын мах, хүнсний дайвар бүтээгдэхүүн экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс есөн хувиар өсжээ

» ХАНШ

15

Өдөр. БНХАУ-ын Төв банк таамаглаж байснаас өндөр буюу ам.доллар юанийн албан ханшийг 6.8992 гэж тогтоон, 15 өдрийн турш унасан үзүүлэлтийг зогсоолоо.

» НӨӨЦ

15

Мянган тонн. Ирэх жил нөөцийн махыг дөрөв дахин ихэсгэж, 15 мянган тонн болгох чиглэл Засгийн газраас өглөө.

» ТЭЭВЭР

155

Хүн. БНСУ-ын инженерүүд УБ хотод 115 хүний суудалтай цахилгаан соронзон галт тэрэг явуулах төсөл танилцууллаа. Цахимаар төлбөрөө төлдөг, жолоочгүй, ухаалаг технологиор удирддаг тул эдийн засагт хэмнэлттэй гэв.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ-ын доллар	2,647.34
Евро	2,9490.40
Японы иен	24.00
ОХУ-ын рубль	41.07
БНХАУ-ын юань	382.85
БНСУ-ын вон	2.22

ЦАЛИН

Уул уурхайн салбарт ажиллагсдын дундаж цалин 2.5 сая төгрөг болов

Т.Элиса
Шинжээч



Улсын хэмжээнд дундаж цалин 1.1 сая төгрөг, медиан цалин 806 мянган төгрөг байгаа бол уул уурхайн салбарт ажиллагсдынх 2.5 сая гаруй төгрөг байна гэж ҮСХ мэдээлсэн. Уул уурхайн салбарт өнөөдрийн байдлаар 47 мянган хүн ажиллаж байгаагаас экспортлогч компаниуд гол ажил олгогчид болж байна. Тухайлбал, Оюу Толгой төсөлд нийт 16,600 хүн ажиллаж байгаагийн 92.6 хувь нь монголчууд аж. "Төслийн ажиллах хүчний тоо оргил цэгтээ хүрсэн учраас цаашдаа буурна" гэж Rio Tinto-ийн Зэс, очир эрдэнийн группын захирал Арнауд Суарат мэдээлж байв. Харин нүүрс экспортлогчдын томоохон төлөөлөл "Тавантолгой" ХК нийт 197 ажилтантай, бүгд монгол хүн байдаг талаар тайландаа тусгажээ.

ЭКСПОРТ

АНУ руу татваргүй экспортлох хууль оны сүүлээр хэрэгжинэ

Б.Бямбасүрэн
Шинжээч

АНУ-ын Конгрессоор хэлэлцэж байгаа Гуравдагч хөршийн худалдааны хууль энэ оны сүүлээр батлагдах хүлээлттэй байгаа гэж Гадаад харилцааны яам мэдээллээ. Монголд үйлдвэрлэсэн оёмол, сүлжмэл бүтээгдэхүүнийг АНУ-д татваргүй экспортлох боломжийг энэхүү хуулиар олгоно. Ингэснээр хоёр улсын худалдааг нэмэгдүүлэх, экспорт нэг улс, нэг салбарын бүтээгдэхүүнээс хамаарах хамаарлыг багасгах нөхцөл бүрдэнэ гэж үзэж байгаа юм. Монгол Улс Европын Холбооны "GSP Plus" хөнгөлөлтийн системд хамрагдахдаа 7200 нэр төрлийн бүтээгдэхүүнийг татваргүй экспортлох боломж нээгдсэн ч ердөө 20 орчим нэр төрлийн бараа, бүтээгдэхүүн гаргаж байгаа нь хангалтгүй гэж МҮХАҮТ үзжээ.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019.05.24-ний өдөр

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй "Гудамж талбайн тохижилт, камержуулалт, гэрэлтүүлгийн ажил" /ХУД, 9, 10, 14, 16 дугаар хороо/-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: НХААГ-19/083

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендерт оролцогчдоос "Гудамж талбайн тохижилт, камержуулалт, гэрэлтүүлгийн ажил" /ХУД, 9, 10, 14, 16 дугаар хороо/-ыг түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 (тавин мянга) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 45 хоногийн туршид хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Байгууламжийн зураг, төсөл боловсруулах, барих, түүний тоног төхөөрөмжийг хүргэх, суурилуулах ажлын нийт мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлтийг нь тооцох жилийн тоо:

Сүүлийн 3 жил буюу 2016, 2017, 2018 онуудын аль нэг жилд борлуулалтын орлого нь төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:

Төсөвт өртгийн 30 хувиас багагүй байх.

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:

Сүүлийн 3 жил буюу 2016, 2017, 2018 оны жилийн эцсийн баталгаажуулсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт ирүүлнэ.

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:

Сүүлийн 3 жил буюу 2016, 2017, 2018 оны аль нэг жилдтөсөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байх.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:Тийм

Зураг төсөл боловсруулах байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй байх бөгөөд хуулбарыг ирүүлнэ.

Эрчим хүчний яамнаас олгодог:

03.9.3 0.4-110 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах буюу түүнээс дээш заалт бүхий тусгай зөвшөөрөлтэй байх

Эсхүл

Барилга, хот байгуулалтын яамнаас олгодог:

ЗТ-3.6 Цахилгаан дамжуулах гол шугам, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг /35кВ хүртэл/ буюу түүнээс дээш заалт бүхий тусгай зөвшөөрөлтэй байх

Гэрэлтүүлгийн угсралтын ажил гүйцэтгэх байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй байх бөгөөд бөгөөд хуулбарыг ирүүлнэ.

Эрчим хүчний яамнаас олгодог:

03.2.1 0.4-10 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ буюу түүнээс дээш заалт бүхий тусгай зөвшөөрөлтэй байх

Эсхүл

Барилга, хот байгуулалтын яамнаас олгодог:

БА-3.5 Цахилгаан дамжуулах шугам сүлжээ, дэд станц, түүний тоног төхөөрөмжийн угсралт буюу түүнээс дээш заалт бүхий тусгай зөвшөөрөлтэй байх

Тендерийн хамт 6,000,000 төгрөг /зургаан сая/-ийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2019 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 15 цаг 00 минутаас өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 15 цаг 30 минутад Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 1012 тоот өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд оролцох эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон холбогдох бусад материалыг www.tender.gov.mn, www.ub-procurement.mnцахим хуудаснаас, бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу-15,
Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар,
Утас: 75757810

Эдийн засаг

Манай экспорт Хятадын ганц өдрийн хэрэгцээг ч хангахгүй

Хятадын махны далай шиг зах зээлийн дэргэд Монголын нийлүү-лэлт дусал мэт аж

Г.Байгал
@baigalZGM

С.Батсайхан / ЗГМ©

Олон улсын зах зээлд гахайн гаралтай түүхий эдийн ханш ийн өссөнөөс хэрэглэгчид бусад төрлийн мах, махан бүтээгдэхүүнийг сонгох нь нэмэгдэж байгаа юм.

Дэлхийн махны нийлүүлэлтийн 30 хувийг зооглодог БНХАУ-ыг Африкийн гахайн мялзан өвчин нөмрөөд нэг жилийн нүүр үзэх гэж байна. Өнгөрсөн оны наймдугаар сард өмнөд хөршид анхны тохиолдол нь бүртгэгдсэн энэ өвчин тус улсын 31 мужид илэрч, сая гаруй гахайг устгасан гэж НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага мэдээллээ. Энэ аюулт өвчин урд хөршийн дотоодын аж ахуй эрхлэгчдийг айдаст автуулж, гадаадын нийлүүлэлтийг суга өсгөжээ. Ялангуяа, Австрали, Япон, Шинэ Зеланд зэрэг улсад гахайн мялзан өвчин БНХАУ-ыг чиглэх махны экспортоо огцом өсгөх том боломж олгоод байна.

Гахайн мах бол Хятадын хүнсний гол бүтээгдэхүүний нэг. Тус улсын махны нийт эрэлтийн 60 хувийг гахайн мах дангаараа бүрдүүлдэг. Гэтэл халдварт өвчин гарснаас үүдэн тус бүтээгдэхүүний нийлүүлэлт буурч, махны ханш магнагт гарчээ. Хятад болон Чикагогийн фьючерс биржид гахайн махны үнэ 50 хувиар дээшилсэн байна.

Олон улсын зах зээлд гахайн гаралтай түүхий эдийн ханш ийн өссөнөөс хэрэглэгчид бусад төрлийн мах, махан бүтээгдэхүүнийг сонгох нь нэмэгдэж байгаа юм. Ингэснээр дэлхийн өнцөг булан бүрээс Хятадыг чиглэх үхэр, хонь, шувуу болон далайн гаралтай мах, махан бүтээгдэхүүний нийлүүлэлт эрс өсжээ. Ялангуяа, үхрийн махны худалдаа Хятадад ид цэцэглэж байна. Австралид үржүүлдэг "вагю" буюу япон үүлдрийн үхрийн махны эрэлт огцом өсөөд байгаа аж. Хэдийгээр тус үүлдэр БНХАУ-аас 7200 километрийн алсад оршдог ч дээд зэрэглэлийн стэйкний махыг худалдан авах хятад үйлчлүүлэгчдийн захиалга энэ оны тавдугаар сард жилийн өмнөх үеэс 50 хувиар нэмэгджээ. Ер нь Хятадын үхрийн махны импорт 2018 онд нэг сая тонн давснаар тус улс уг бүтээгдэхүүний гол зах зээлд тооцогдож эхэлсэн юм.

Мөн энэ онд Хятадын гахайн махны импорт хоёр дахин өсөж, хоёр сая тоннд хүрэх төлөвтэй байгааг Rabobank-ийн шинжээчид таамаглаж байна. БНХАУ-ын макро эдийн засгийн тасралтгүй өсөж, хүн амын орлого нэмэгдсэнээр сүүлийн 30 жилд урд хөршийн махны эрэлт тасралтгүй тэлсээр буй. Тухайлбал, 2011 онд өмнөд хөршийн нэг иргэний махны жилийн дундаж хэрэглээ 43.8 килограмм байсан бол 2018 онд энэ тоо 10 килограммаар нэмэгдэж, 53-т хүрснийг Statista байгууллага тооцоолжээ.

Тэгвэл НҮБ-ын тооцоогоор Хятад улсын хүн амын тоо 2018 оны байдлаар 1.4 тэрбумыг давсан. Хятадын хүн амын тоо, махны дундаж хэрэгцээг тойм байдлаар тооцвол урд хөршийн махны нийт эрэлт ойролцоогоор 75 сая тонноор хэмжигдэж байна. Тэгвэл үүнийг нэг өдөрт хуваавал өмнөд хөршийн иргэд өдөрт дунджаар 208 мянган тонн мах зооглодог гэсэн үг. Гэтэл энэ нь Монгол Улсын бүтэн жилийн турш Хятадад нийлүүлж буй нийт махны экспортоос долоо дахин өндөр дүн юм.

Гаалийн ерөнхий газрын мэдээллээр Монгол Улс өнгөрсөн онд урд хөршид адууны 29 мянга, хонь болон ямааны 24 тонн мах нийлүүлжээ. Гэтэл бидний бүтэн жилийн махны нийлүүлэлт урд хөршийн нэг өдрийн хэрэгцээний ердөө 10 гаруйхан хувийг л хангаж дөнгөх нь. Тэгвэл урд хөрш төдийгүй бусад зах зээлийг чиглэсэн Монгол Улсын махны нийт экспорт 2018 онд 54.9 мянган тоннд хүрсэн. Энэ нь сүүлийн жилүүдэд ажиглагдаагүй өндөр үзүүлэлт болсныг салбарын яам онцолж байгаа. Гэлээ ч гэсэн энэ түүхэн гээд байгаа өсөлт Хятадын махны нэг өдрийн хэрэгцээний дөрөвний нэгийг л бүрдүүлэхээр байна.

Үүнээс үзэхэд Хятадын далай шиг зах зээлийн дэргэд Монголын нийлүүлэлт дусал мэт болж таарч байна. Гэтэл урд хөршийг чиглэх махны нийлүүлэлт ялимгүй өссөнөөс үүдэн өнгөрсөн саруудад манайд махны хомсдол үүсэж, үнэ ханш нь тэнгэрт тулсан. Цаашлаад нийгмийн бухимдал үүсэж, үймээн шуугиан хүртэл өрнөх болсон. Өөрөөр хэлбэл, Хятадын өдрийн хэрэгцээг ч хангахгүй махны нийлүүлэлт Монголын ард түмнийг сүүлийн хэдэн сар үнийн өсөлтөд дарлуулж, хоосон хонох шахам болгосон байна.

Салбарын яамны мэдээлснээр үнийн өсөлтөд хамгийн түрүүнд халаасаа сэгсрүүлж буй нийслэлчүүдийн жилийн махны хэрэглээ 100-120 мянган тонноор хэмжигддэг байна. Ийм жижиг зах зээлийг хөндлөнгөөс удирдаж, зохиомлоор хомсдол үүсгэн, үнэ ханшаар тоглох боломж байдаг аж. Засгийн газраас өгсөн үүрэг чиглэлийн дагуу тагнуулын байгууллага өнгөрсөн долоо хоногт шалгалт хийхэд зарим компани махны хомсдол зохиомлоор үүсгэж, их хэмжээний мах агуулахдаа нөөцөлж байсан нь тогтоогдсон.

Тиймээс ард иргэдээ хүнсээр хангахын тулд төр махны нийлүүлэлтэд зайлшгүй анхаарал хандуулах хэрэгтэй болов. Монголчуулын хоолны үндсэн орц болсон, стратегийн хүнсээр иргэдээ хангахын тулд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас экспортод квот тогтоохоо мэдэгдсэн. Ялангуяа, ямар нэг хязгаарлалтгүй гадаад зах зээлд нийлүүлсээр хонь, ямааны махны экспортод квот тогтоох аж. Ингэснээр дотоодын зах зээлийн тогтвортой байдлыг хангаж, үнийн хөөргөдлөөс сэргийлнэ. Мөн Хятадын талаас эрүүл ахуйн шаардлага хангаагүй мах нийлүүлсэн гэх гомдол иржээ.

Ирэх жилүүдэд мал, амьтны гаралтай өвчин махны зах зээлийн чиг хандлагыг өөрчлөхөөр байна. Гахайн мялзан өвчин ирэх жилүүдэд дэлхийн махны зах зээлд нөлөөлнө хэмээн Meat & Livestock Australia худалдааны группийн зах зээлийн шинжээчид таамаглаж байна. Тэгэхээр ирэх жилүүдэд ч гэсэн урд хөршийн махны эрэлт улам нэмэгдэж, импорт нь өсөх төлөвтэй. Энэ нь өмнөх саруудынх шиг Монголд нөлөөлж, дотоодын махны үнийг өдөөж магадгүй. Тиймээс Монголын ард түмнийг сөхрүүлсэн махны үнэ, ханшийг тогтоон барихын тулд салбарын яам шуурхай бөгөөд дорвитой алхам хийж эхэлж байгаа аж. [ЗГМ]